

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР**

2023 оны 11 дүгээр сарын 03

**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД ШААРДЛАГАТАЙ ОФФИСЫН  
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ ЕРӨНХИЙ ГЭРЭЭГЭЭР ХУДАЛДАН АВАХ” ТӨСӨЛ АРГА,  
ХЭМЖЭЭНИЙ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: “Төрийн байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай  
оффисын техник хэрэгслийг ерөнхий гэрээгээр худалдан авах”

Тендерийн дугаар: ТХААГ/202311161

Улаанбаатар хот  
2023 он

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА ГАРЧИГ

#### **А. Ерөнхий зүйл**

1. Тендерийн цар хүрээ
2. Санхүүжилтийн эх үүсвэр
3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл
4. Эрх бүхий тендерт оролцогч
5. Эрх бүхий бараа, үйлчилгээ
6. Түншлэл

#### **Б. Тендерийн баримт бичиг**

7. Тендерийн баримт бичгийн агуулга
8. Тендерийн баримт бичгийг тодруулах
9. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах

#### **В. Тендер бэлтгэх**

10. Тендер шалгаруулалтад оролцох зардал
11. Тендерийн хэл
12. Тендерийн иж бүрдэл
13. Тендерийн маягт болон үнийн хуваарь
14. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт
15. Тендерийн валют
16. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт
17. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт
18. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичигт нийцэж буйг нотлох баримт
19. Тендер хүчинтэй байх хугацаа
20. Тендерийн баталгааны мэдэгдэл
21. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах

#### **Г. Тендер ирүүлэх**

22. Тендерийг битүүмжлэх
23. Тендер хүлээн авах эцсийн хугацаа
24. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх
25. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах

#### **Д. Тендерийг нээх, үнэлэх**

26. Тендерийг нээх
27. Нууцлал
28. Тендерийн тодруулга
29. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцэх эсэхийг тогтоох
30. Алдааг залруулах
31. Нэг валютад хөрвүүлэх
32. Дотоодын тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцох
33. Тендерийг үнэлэх, харьцуулах
34. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах
35. Аливаа тендерийг сонгох, эсвэл тендерүүдээс татгалзах мэргэжлийн байгууллагын эрх

#### **Е. Гэрээ байгуулах эрх олгох**

36. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур
37. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
38. Гэрээнд гарын үсэг зурах
39. Гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэл

#### **Ж. Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалт**

40. Хоёрдугаар шатны шалгаруулалт
41. Шууд сонголтын арга
42. Цахим үнэ хаялцуулах арга
43. Үнийн санал авах арга
44. Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ байгуулах

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

### А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1. Тендерийн цар хүрээ**
  - 1.1. Төрийн худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “Мэргэжлийн байгууллага” гэх) нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан бараа, материал, тоног төхөөрөмж(цаашид “бараа” гэх), эсхүл ТШӨХ болон ажлын даалгаварт заасан үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх)-г Ерөнхий гэрээ байгуулан худалдан авахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.
  - 1.2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид ТШӨХ гэж товчлох)-д тодорхойлсон Захиалагч бараа, үйлчилгээний эцсийн хэрэглэгч байна.
  - 1.3. Тендер шалгаруулалт нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна.
  - 1.4. Олон багцтай тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийг багц тус бүрээр үнэлж зарахыг хориглоно.
  - 1.5. Тендерт шалгарч, Ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн бараа эсхүл ажлын даалгаварт нийцсэн үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулсан хугацаанд бараа нийлүүлэх болон үйлчилгээ үзүүлэх хуваарьт заасны дагуу зохих газарт хүргэх үүрэгтэй. Мөн Ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний үүргээ биелүүлэх үүрэгтэй.
  - 1.6. Мэргэжлийн байгууллага нь уг бараа, үйлчилгээг худалдан авах Ерөнхий гэрээ байгуулахаар хууль, журам д тусгайлан заасан шаардлага хангаж, “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн ТШӨХ-д заасан тооны нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулна.
  - 1.7. Шалгарсан тендерт оролцогчтой ТШӨХ-д заасан хугацаагаар гэрээ байгуулах бөгөөд энэ хугацаанд захиалагч цахим дэлгүүрээр дамжуулан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн санал болгож буй бараа, үйлчилгээнээс худалдан авна.
- 2. Санхүүжилтийн эх үүсвэр**
  - 2.1. Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрээр санхүүжүүлнэ.
- 3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл**
  - 3.1. Төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцож гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.
  - 3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Өрсөлдөөний тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлига, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой

мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.

#### **4. Эрх бүхий тендерт оролцогч**

- 4.1. Тендерийн урилга нь сонирхсон этгээд бүрд нээлттэй. Хуулийн 9 дүгээр 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харьяалалтай байж болно.
- 4.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрд нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:
  - 4.2.1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;
  - 4.2.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;
  - 4.2.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бүтэц, зохион байгуулалт болон санхүүгийн хувьд Мэргэжлийн байгууллага болон захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол;
  - 4.2.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, хуулийн 52<sup>1</sup> дүгээр зүйлийн 52<sup>1</sup>.1 дэх хэсэгт заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон;
  - 4.2.5. Тендерт оролцогч (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
  - 4.2.6. Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг хуулийн 52<sup>1</sup> дүгээр зүйлийн 52<sup>1</sup>.1 дэх хэсэгт заасан эрх бүхий улсын байцаагч тогтоосон;
  - 4.2.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;
  - 4.2.8. Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
  - 4.2.9. Энэхүү тендерийн баримт бичигт зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол;(Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг

нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)

4.3. Тендерт оролцогч 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг Мэргэжлийн байгууллагад бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор Мэргэжлийн байгууллагаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог Мэргэжлийн байгууллагад ирүүлнэ.

## **5. Эрх бүхий бараа, үйлчилгээ**

5.1. Захиалагч төлбөрийг зөвхөн ТООЗ-ны 1.1-д дурдсан бараа, үйлчилгээг хүлээн авснаар төлнө.

5.2. Гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

5.3. Энэхүү зааварчилгааны 5.2-т дурдсан барааны гарал үүсэл гэдэгт тухайн барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн улс орон буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

## **6. Түншлэл**

6.1. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл”, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер ирүүлэх тохиолдолд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

(а) түншлэлийн бүх гишүүний хувьд тендер хүчин төгөлдөр байхаар тендерт гарын үсэг зурсан байх;

(б) ТООЗ-ны 1.1-д заасан бараа нийлүүлэх эсхүл үйлчилгээ үзүүлэх Ерөнхий гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг тодорхойлж, хамтран ажиллах гэрээнд тодорхойлсон байх;

(в) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;

(г) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөр тооцоог зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй харилцаж, гүйцэтгэх тухай хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх;

(д) түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх.

## **Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

## **7. Тендерийн баримт бичгийн агуулга**

7.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ. Үүнд:

### **I ХЭСЭГ**

- Бүлэг 1. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
- Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
- Бүлэг 3. Тендер шалгаруулалтын маягт
  - Тендерийн маягт

- Үнийн хуваарь
- Тендерийн баталгааны мэдэгдэл
- Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн зөвшөөрлийн маягт

## II ХЭСЭГ

Бүлэг 4. Техникийн тодорхойлолт, ажлын даалгавар болон бусад шаардлага

## III ХЭСЭГ

Бүлэг 5. Гэрээний ерөнхий нөхцөл

Бүлэг 6. Гэрээний тусгай нөхцөл

Бүлэг 7. Гэрээний маягт

- Гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэл

Хавсралт: Тендерийн урилга

7.2. Мэргэжлийн байгууллагын нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

7.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно.

## 8. Тендерийн баримт бичгийг тодруулах

8.1. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) дэх “Тодруулга” хэсэгт ирүүлнэ. Мэргэжлийн байгууллага тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан тодруулгад хариу өгнө.

8.2. Тодруулгын агуулга, түүнд өгөх Мэргэжлийн байгууллагын хариуг тодруулгын эх сурвалжийг дурдалгүйгээр цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д байршуулан, нийтэлнэ.

8.3. Тендерт оролцохыг сонирхсон этгээд цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д нийтэлсэн тодруулгын хариутай танилцах үүрэгтэй.

8.4. Тухайн тодруулгын үр дүнд Мэргэжлийн байгууллага тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл энэхүү ТООЗ-ны 9 дүгээр зүйл, 23.3 дахь хэсэгт заасан журмыг баримтална.

## 9. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах

9.1. Мэргэжлийн байгууллага тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.2. Ийнхүү оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д байршуулан, олон нийтэд мэдэгдэнэ.

9.3. Тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийг бэлтгэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчид олгох шаардлагатай гэж үзвэл Мэргэжлийн байгууллага ТООЗ-ны 23.3-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

## **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

### **10. Тендер шалгаруулал-тад оролцох зардал**

10.1. Тендерт оролцогч тендер бэлтгэх, Мэргэжлийн байгууллагад ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд Мэргэжлийн байгууллага ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.

### **11. Тендерийн хэл**

11.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор Мэргэжлийн байгууллага тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидлууд болон бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. Тендерийн баримт бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвөл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.

11.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТООЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.

### **12. Тендерийн иж бүрдэл**

12.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

(а) ТООЗ-ны 13, 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендерийн маягт болон үнийн хуваарь;

(б) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТООЗ-ны 16 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;

(в) тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТООЗ-ны 17 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;

(г) нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээ, эсхүл үзүүлэх үйлчилгээ болон түүнийг дагалдах бараа, материал, тоног төхөөрөмж нь тендерийн баримт бичигт нийцэж буйг баталгаажуулсан ТООЗ-ны 18 дугаар зүйлд заасан нотлох баримт;

(д) Тендерийн баталгааны мэдэгдэл;

(е) ТШӨХ-д шаардсан ТООЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэх бусад материал.

### **13. Тендерийн маягт болон үнийн хуваарь**

13.1. Тендерт оролцогч нь Бүлэг 3-т заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.

**14. Тендерийн  
үнэ болон  
үнийн  
хөнгөлөлт**

- 13.2. Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа, үйлчилгээний үнийн хуваарийг бэлтгэн ирүүлнэ. Үнийн хуваарийг 3 дугаар бүлэгт заасан тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягтыг ашиглан бэлтгэнэ.
- 14.1. Тендерт оролцогч ТШӨХ-д зааснаас хэтрэхгүйгээр санал болгож буй бараа, үйлчилгээний нэгж үнийг ирүүлнэ.
- 14.2. Тендерийн маягт болон үнийн хуваарь, тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон үнийн хөнгөлөлт нь дор тодорхойлсон шаардлагад нийцсэн байна.
- 14.3. Үнийн хуваарьт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.
- 14.4. Тендерийн маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн бараа, үйлчилгээний нэгж үнэ байна.
- 14.5. Олон улсын худалдааны EXW, CIF болон ижил төстэй бусад нөхцөлийг хэрэглэхдээ ТШӨХ-д дурдсан, Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргасан Incoterms-ийн хамгийн сүүлийн хувилбарыг удирдлага болгоно.
- 14.6. Нийлүүлэх бараа, үзүүлэх үйлчилгээний үнийг тендерийн маягт (Бүлэг3)-д заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан нэр, төрөл бүрээр холбогдох үнийн хуваарьт тусгаж ирүүлнэ.
- 14.7. Гэрээ болон бусад үндэслэлээр нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна. Уг тендерийн үнэ нь Ерөнхий гэрээний хүчинтэй хугацаанд тогтмол байна.
- 14.8. Бараа, үйлчилгээг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТООЗ-ны 1.2 дахь заалт болон түүнд харгалзах ТШӨХ-ийн заалтаас үзнэ үү! Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.
- 14.9. Үнийн хуваарьт дараах зүйлсийг тусад нь бичиж харуулна.  
Үүнд:
- (а) Монгол Улсад үйлдвэрлэгдсэн барааны хувьд:
1. барааны EXW үнэ (үйлдвэрийн, агуулахын, эсхүл лангууны үнийн аль тохирохыг). Энэ үнэд барааг үйлдвэрлэх, угсрахад ашигласан үйлдвэрийн, эсхүл лангууны үнээр үнэлэгдсэн эд анги, түүхий эд, үйлдвэрлэлийн бусад өртөг багтана;
  2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг нэмэгдсэн өртгийн болон бусад адилтгах албан татвар;
  3. хэрэв ТШӨХ-д барааг хүргэх газрыг заасан бол эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.



(б) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны хувьд:

1. ТШӨХ-д Мэргэжлийн байгууллагын эрлэсэн хилийн боомт хүртэлх СИФ/CIF/ үнэ, эсхүл Монгол улсын нутаг дэвсгэр дэх нэрлэсэн байрлал хүртэлх СИП /CIP/ үнэ;
2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирэх бараанд ногдох гаалийн, нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;
3. хэрэв ТШӨХ-д барааг орох боомтоос буюу нэрлэсэн байрлалаас барааг хүргэх газрыг заасан бол эцсийн цэгт хүргэхэд шаардагдах хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(в) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд:

1. барааны үнэ буюу импортоор анх орж ирсэн тухайн барааны үнэ дээр үнийн нэмэгдэл/эсхүл хөнгөлөлт/, дотоодод гарсан аливаа нэмэлт өртөг, тухайн бараанд төлсөн эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татваруудыг тооцсон үнэ;
2. импортлогдсон бараанд урьд төлсөн (нотлох баримтыг хамт ирүүлэх шаардлагатай), эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татварууд;
3. тухайн барааг олж авахад зарцуулсан өртөг буюу энэ заалтын 1 болон 2 –ын ялгавар;
4. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирсэн бараанд ногдох нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;
5. хэрэв ТШӨХ-д барааг хүргэх газрыг заасан бол эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(д) Ажлын даалгаварт заасан үйлчилгээний хувьд:

1. Ажлын даалгаварт заасан үйлчилгээний үнэ дээр үнийн нэмэгдэл /эсхүл хөнгөлөлт/, дотоодод гарсан аливаа нэмэлт өртөг, тухайн үйлчилгээнд төлсөн эсхүл төлөгдөх татвар, хураамжуудыг тооцсон үнэ;
2. хэрэв ТШӨХ-д үйлчилгээ үзүүлэх газрыг заасан бол уг газарт хүрэхэд шаардлагатай тээвэр, даатгал болон бусад зардал.

(г) Ажлын даалгаварт заасан үйлчилгээний Дагалдах бараа, материал, тоног төхөөрөмжийн хувьд:

1. Монгол Улсад үйлдвэрлэгдсэн бараа, материал, тоног төхөөрөмжийн хувьд ТШӨХ-ийн 15.12 (а)-д заасныг баримтална.
2. Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны хувьд ТШӨХ-ийн 15.12 (б)-д заасныг баримтална.
3. Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд ТШӨХ-ийн 15.12 (в)-д заасныг баримтална.

14.10. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь Ерөнхий гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн

явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТООЗ-ны 29 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.

14.11. ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

14.12. Ерөнхий гэрээний үнэ нь үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**15. Тендерийн валют**

15.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.

**16. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт**

16.1. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:

- (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар;
- (б) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх эсхүл үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл.

**17. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт**

17.1. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Мэргэжлийн байгууллагын шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:

- (а) хэрэв ТШӨХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг 3 дугаар бүлгийн маягтаас тохирох маягтыг ашиглан ирүүлнэ;
- (б) гэрээг хэрэгжүүлэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
- (в) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;
- (г) хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;
- (д) Мэргэжлийн байгууллага тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;
- (е) Тендерт оролцогч нь тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдсан эсэх тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;
- (ё) гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээлэл.

17.2. Тендерт оролцогч ТООЗ-ны 1.1-д заасан бараа нийлүүлэх эсхүл үйлчилгээ үзүүлэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна.Үүнд:

- (а) сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан дүнгээс багагүй байх;
- (б) сүүлийн [ТШӨХ-д заасан тоо]жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг бараа нийлүүлэх үндсэн нийлүүлэгчээр ажилласан туршлага, эсхүл үндсэн үйлчилгээ үзүүлэгчээр ажилласан туршлага;
- (в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;
- (г) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглагдаж буй хөрөнгө болон гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.
- (д) сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

17.3. Тендерт оролцогч түншлэл нь 17.2(а) ба (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 17.2 (а), (б), (г) -д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна.

Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагуудыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана. ТШӨХ-д өөрөөр заагаагүй тохиолдолд тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, нөөц бололцоог харгалзан үзэхгүй.

Тендерт оролцогч 17.2(б) ба (в)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохдоо түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно.

17.4. ТШӨХ-д тусгайлан заасан бол Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд 10 хувийн давуу эрх олгоно. Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлэх тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлтэй бол энэ тухайгаа нотлоход шаардлагатай баримт, материалыг тендертэй хамт ирүүлэх үүрэгтэй.

**18. Нийлүүлэх бараа, үзүүлэх үйлчилгээ нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буйг**

18.1. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа, үзүүлэх үйлчилгээ нь Мэргэжлийн байгууллагын шаардсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавар болон стандартад нийцэж буйг нотлох баримтыг тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- (а) бараа, үйлчилгээний техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;

<b>нотлох баримт</b>	<p>(б) нийлүүлэх бараа, үйлчилгээ нь техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч Мэргэжлийн байгууллагын тогтоосон техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл;</p> <p>в) Мэргэжлийн байгууллагын техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч 18.1 (б)-ийн дагуу тайлбар ирүүлнэ.</p> <p>Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч Мэргэжлийн байгууллагад нотлон харуулна.</p>
<b>19. Тендер хүчинтэй байх хугацаа</b>	19.1. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд Мэргэжлийн байгууллага түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.
<b>20. Тендерийн баталгааны мэдэгдэл</b>	<p>20.1. Ерөнхий гэрээгээр бараа, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтад тендерийн баталгааг банкны баталгаа хэлбэрээр ирүүлэхийг шаардахгүй.</p> <p>20.2. Тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заасан тохиолдолд төсвийн хөрөнгөөр худалдан авах аливаа тендер шалгаруулалтад оролцох тендерт оролцогчийн эрхийг тодорхой хугацааны туршид хасахыг хүлээн зөвшөөрсөн тухай тендерийн баталгааны мэдэгдэлд гарын үсэг зурж ирүүлнэ.</p> <p>20.3. Тендерт оролцогч ТӨӨЗ-ны 20.2-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
<b>21. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах</b>	21.1. Тендерт оролцогч ТӨӨЗ-ны 12 дугаар зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн, "pdf" форматад хөрвүүлэн, үндэсний тоон гарын үсгээр баталгаажуулан цахим худалдан авах ажиллагааны систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> )-д ирүүлнэ. Тендерт оролцогчийн системд ирүүлсэн тендерийг "эх хувь" гэж үзнэ.

---

## Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

---

<b>22. Тендерийг битүүмжлэх</b>	<p>22.1. Ерөнхий гэрээгээр бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ээр цахим хэлбэрээр зохион байгуулна.</p> <p>22.2. Цахим хэлбэрээр тендер шалгаруулалт зохион байгуулахдаа төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмыг баримтална.</p>
---------------------------------	---

- 
- 22.3. Тендерт оролцогч нь ТШӨХ-д заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө, түүнд заасан хэлбэрээр цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийг цахимаар ирүүлнэ.
- 22.4. ТООЗ-ны 22.3-т зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн аливаа тендерийг Мэргэжлийн байгууллага хүлээж авахгүй, буцаана.
- 23. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 23.1. Мэргэжлийн байгууллага тендерийг ТШӨХ-д заасан цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 23.2. ТООЗ-ны 23.1 дэх хэсэгт заасан хугацаа дуусахад цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) автоматаар хаагдаж, аливаа хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахгүй.
- 23.3. Мэргэжлийн байгууллага ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд Мэргэжлийн байгууллага болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.
- 24. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх**
- 24.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэл болж тендер шалгаруулалтад оролцоходоо зөвхөн нэг тендер ирүүлнэ. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн, бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана.
- 25. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах**
- 25.1. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө өөрийн тендерт аливаа засвар, өөрчлөлт оруулж цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д хэдэн ч удаа ирүүлж болно. Уг системд хамгийн сүүлд тендер хүлээн авах эцсийн хугацаанд багтааж ирүүлсэн тендер нь тухайн тендерт оролцогчоос ирүүлсэн тендер байна.
- 25.2. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө өөрийн тендерийг цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээс буцаан авах эрхтэй. Энэ тохиолдолд цахим тендер шалгаруулалтад оролцох хураамжийг буцаан олгохгүй.
- 25.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерт ямар нэг нэмэлт, өөрчлөлт хийх, солих, эсвэл буцааж авахыг зөвшөөрөхгүй.

---

#### **Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ**

---

- 26. Тендерийг нээх**
- 26.1. Мэргэжлийн байгууллага тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.

26.2. Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, тендерийн баталгааны мэдэгдэл оролцогч өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийг болон Мэргэжлийн байгууллага шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлтийг тендерийг үнэлгээнд харгалзахгүй.

26.3. Мэргэжлийн байгууллага тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:

(а) тендерт оролцогчийн нэр;

(б) тендерийн үнэ болон санал болгосон үнийн хөнгөлөлт.Нэгээс дээш багцтай тендер шалгаруулалтын үед эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;

(в) Тендерийн баталгааны мэдэгдэл.

## 27. Нууцлал

27.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.

27.2. Мэргэжлийн байгууллага тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.

27.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд Мэргэжлийн байгууллага болон тендерт оролцогчид зөвхөн бичгээр харилцана.

## 28. Тендерийг тодруулах

28.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол Мэргэжлийн байгууллага тендерт оролцогчоос түүний тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсэж болно. Тендерийг тодруулахтай холбоотой аливаа харилцааг бичгээр явуулна.Гэхдээ ТООЭЗ-ны 29 дүгээр зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

## 29. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

29.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө уг тендер нь дараах шаардлагыг хангаж буй эсэхийг хянан үзнэ. Үүнд:

(а) ТООЭЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;

(б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж, баталгаажуулсан эсэх;

(в) зөвшөөрөгдсөн маягтын дагуу шаардлага хангасан тендерийн баталгааны мэдэгдэл ирүүлсэн эсэх;

(г) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх;

(д) тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасан эсэх.

29.2. ТООЗ-ны 29.1 дэх заалтын (а) - (д)-д заасан заалт тус бүрийг хангаж буй тохиолдолд шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

29.3. Мэргэжлийн байгууллага шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

### **30. Алдааг залруулах**

30.1. Мэргэжлийн байгууллага шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:

(а) Тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоон дүнг залруулах.

30.2. Мэргэжлийн байгууллага шаардлагад нийцсэн гэж үнэлэгдсэн тендерийн үнэд залруулга хийсэн бол энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.

### **31. Нэг валютад хөрвүүлэх**

31.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдол ТООЗ-ны 15 дугаар зүйлд зааснаас өөр валютаар тендерийн үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд Мэргэжлийн байгууллага тендерийн үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендерийн үнийг тендер зарласан өдрийн Монгол банкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

### **32. Дотоодын давуу эрх**

32.1. Мэргэжлийн байгууллага ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт бусад гарал үүсэлтэй бараа санал болгосон тендертэй харьцуулахад давуу эрхийн зөрүү олгохгүй.

### **33. Тендерийг үнэлэх, харьцуулах**

33.1. Мэргэжлийн байгууллага зөвхөн ТООЗ-ны 29 дүгээр зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг дараах байдлаар үнэлж, харьцуулна:

33.1.1. Тухайн бараа, үйлчилгээний зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн Мэргэжлийн байгууллагын тогтоосон дээд босго нэгж үнэтэй харьцуулан үнэлэх;

33.1.2. Тендерт оролцогчийн санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцох;

33.1.3. Тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх тооцохоор заасан бол түүнийг үнэлгээнд харгалзах;

33.2. Тендерт оролцогчийн ирүүлсэн үнэ нь 33.1.1-д заасан үнэтэй тэнцүү буюу түүнээс бага үнийн санал ирүүлсэн бол шаардлагад нийцсэн гэж үзнэ.

33.3. Хэрвээ тендерт оролцогчийн үнэ 33.1.1-д заасан үнээс их үнийн санал ирүүлсэн бол шаардлагад нийцээгүй гэж татгалзана.

33.4. Барааг ТООЗ-ны 1.2 дахь хэсэгт хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол Мэргэжлийн байгууллага үнэлгээг багц тус бүрд хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгохдоо нэг

багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль үр ашигтай хувилбарыг сонгож болно.

**34. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**

34.1. Мэргэжлийн байгууллага шаардлагад нийцсэн гэж, үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадалж болно.

34.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 17.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 28 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТООЗ-ны 17.2-т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Мэргэжлийн байгууллага 17.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.

34.3. Шаардлагад нийцсэн гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно.

**35. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах Мэргэжлийн байгууллагын эрх**

35.1. Мэргэжлийн байгууллага тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

---

**Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ**

---

**36. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур**

36.1. Мэргэжлийн байгууллага шаардлагад нийцсэн гэж үнэлэгдсэн гурав буюу түүнээс дээш тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

36.2. Шаардлагад нийцсэн гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТООЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу мэргэжлийн байгууллагын залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй эсвэл бичгээр хариу ирүүлээгүй, гэрээ байгуулахаас татгалзсан бол ТООЗ-ны 20.2-д заасны дагуу тендерт оролцогчийн эрхийг тодорхой хугацааны туршид хасна.

**37. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл**

37.1. Мэргэжлийн байгууллага нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргаж, тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлэх бөгөөд системд нийтэлнэ.

37.2. Шалгарсан тухай мэдэгдэлд цахим дэлгүүрт байрлуулах тухайн тендерт оролцогчоос ирүүлсэн бараа, үйлчилгээний нэгж үнийг заана. Уг үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг тооцсон тендерийн нэгж үнэ байна.

37.3. Мэргэжлийн байгууллага цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д тендерийн нэр болон багцын дугаарыг дараах мэдээллийн хамтаар гэрээ байгуулах эрх олгосон даруй нийтэлнэ. Үүнд:



- (а) Ерөнхий гэрээний тендерт оролцогчийн нэр, ирүүлсэн үнийн санал;
- (б) Гэрээ байгуулах эрх олгогдсон тендерт оролцогчийн жагсаалт, тэдгээрийн үнэлгээ;
- (в) Гэрээ байгуулах эрх олгогдсон тендерт оролцогчийн ирүүлсэн тендер нь ерөнхий гэрээний дагуу худалдан авах барааны техникийн тодорхойлолт, үйлчилгээний ажлын даалгавартай нийцсэн эсэх талаарх дүгнэлт;
- (г) Татгалзсан болон шаардлага хангаагүй тендерт оролцогчийн жагсаалт, татгалзсан үндэслэл;
- (д) Тендерийн үнэлгээний хураангуй дүгнэлт.

37.4. Гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг мэдээлсний дараа шалгараагүй тендерт оролцогч өөрийн тендерийн үнэлгээний талаар тайлбар авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Хүсэлт гаргасан тохиолдолд Мэргэжлийн байгууллага бичгээр хариу өгнө.

37.5. Тендер нь шалгарсан оролцогч ТООЗ-ны39 дүгээр зүйлийн дагуу Гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэл гаргаж, гэрээний маягтад гарын үсэг зурж ирүүлсэн даруй Мэргэжлийн байгууллага тендерт оролцогчтой гэрээ байгуулна.

**38. Гэрээнд гарын үсэг зурах**

38.4. Мэргэжлийн байгууллага гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

38.5. Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаан түүнд гарын үсэг зурж Мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ.

38.6. Мэргэжлийн байгууллага шалгарсан тендерт оролцогчийг Гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэл ирүүлсний дараа ТООЗ-ны 38-д нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.

**39. Гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэл**

39.4. Ерөнхий гэрээгээр бараа, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтад гүйцэтгэлийн баталгааг банкны баталгаа хэлбэрээр шаардахгүй.

39.5. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заасан тохиолдолд төсвийн хөрөнгөөр худалдан авах аливаа тендер шалгаруулалтад оролцох тендерт оролцогчийн эрхийг тодорхой хугацааны туршид хасахыг хүлээн зөвшөөрсөн тухай гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэлд гарын үсэг зурж ирүүлнэ.

39.6. Шалгарсан тендерт оролцогч ТООЗ-ны 39.2-т заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд орох үндэслэл болно.

---

**Ж. ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ ХОЁРДУГААР ШАТНЫ ШАЛГАРУУЛАЛТ**

---

**40. Хоёрдугаар шатны**

40.1. Ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл, гэрээний үнэ, санал болгож буй

**шалгаруула  
лт**

бараа, үйлчилгээний холбогдох мэдээллийг цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ийн цахим дэлгүүрийн санд бүртгэж, байршуулна.

- 40.2. Захиалагч нь цахим дэлгүүрт бүртгэгдэж, ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн санал болгож буй бараа, үйлчилгээг хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтын аргад үндэслэн худалдан авч, худалдан авах гэрээ байгуулна.
- 40.3. Хоёрдугаар шатны шалгаруулалт нь шууд сонголт, цахим үнэ хаялцуулах, үнийн санал авах гэсэн аргад үндэслэнэ.
- 40.4. Мэргэжлийн байгууллага нь тендерийн баримт бичгийн ТШӨХ-д хоёрдугаар шатны шалгаруулалтын аргыг заана.
- 40.5. Тендерийн баримт бичгийн ТШӨХ-д заасан хоёрдугаар шатны шалгаруулалтын аргаас өөр аргаар уг ажиллагааг явуулахыг хориглоно.
- 40.6. Захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, нийлүүлэлтийн хуваарь, үйл ажиллагааны хуваарь зэрэг мэдээлэл бүхий захиалгын хуудсыг цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр ирүүлнэ.
- 40.7. Захиалагчаас худалдан авах бараа, үйлчилгээний захиалгын хуудас ирсэн даруйд мэргэжлийн байгууллага цахим дэлгүүрт бүртгэгдэж, ерөнхий гэрээ байгуулсан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчид хоёрдугаар шатны шалгаруулалтын тов бүхий урилгыг цахим систем болон утсаар мэдэгдэж, цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр зохион байгуулна.

**41. Шууд  
сонголтын  
арга**

41.1. “Шууд сонголт” гэж захиалагч цахим худалдан авах ажиллагааны систем дэх цахим дэлгүүрийн санд бүртгэгдсэн бараа, үйлчилгээнээс худалдан авах тоо хэмжээ, хүргэх газар нь тодорхой тохиолдолд сонголт хийхийг хэлнэ.

**42. Цахим үнэ  
хаялцуулах  
арга**

42.1. “Цахим үнэ хаялцуулах ажиллагаа” гэж цахим худалдан авах ажиллагааны систем дэх цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн тендерийн үнийг хамгийн бага үнийн дүнгээр нь автоматаар эрэмбэлэх ажиллагааг хэлнэ.

42.2. Худалдан авах бараа, үйлчилгээний нэгж үнийг бууруулах зорилгоор цахим үнэ хаялцуулах аргыг цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр дамжуулан мэргэжлийн байгууллага зохион байгуулна.

42.3. Цахим үнэ хаялцуулах ажиллагааны урилга хүргүүлснээс хойш үнийн санал хүлээн авах эцсийн хугацаанд багтаан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь хэдэн ч удаа үнийн саналаа цахимаар ирүүлж, үнэ хаялцуулах ажиллагаанд оролцож болно.

**43. Үнийн санал авах арга**

43.1. “Үнийн санал авах ажиллагаа” гэж цахим худалдан авах ажиллагааны систем дэх цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээс ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээний хүргэх газар, тоо хэмжээ, хамрах хүрээнд эцсийн үнийг авахыг хэлнэ.

43.2. Худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар нь эцэслэн тодорхой болсон тохиолдолд тухайн тоо, хэмжээ, хүргэх газарт үндэслэсэн эцсийн үнийг авах зорилгоор үнийн санал авах аргыг цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр дамжуулан мэргэжлийн байгууллага зохион байгуулна.

43.3. Үнийн санал авах ажиллагааны урилга хүргүүлснээс хойш үнийн санал хүлээн авах эцсийн хугацаанд багтаан нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нь нэг л удаа эцсийн үнийн саналаа цахимаар ирүүлж, үнийн санал авах ажиллагаанд оролцоно.

**44. Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ байгуулах**

44.1. Захиалагч нь шууд сонголтын аргын дагуу цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ийн цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээг сонгон авч, нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй худалдан авах гэрээ байгуулна.

44.2. Цахим үнэ хаялцуулах ажиллагаанд хамгийн бага үнийн санал ирүүлсэн нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй захиалагч худалдан авах гэрээ байгуулна.

44.3. Үнийн санал авах ажиллагаанд нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн үнийн санал, ажлын хуваарь, бараа нийлүүлэлтийн хуваарь, хүргэлтийн нөхцөл зэргийг харгалзан захиалагч худалдан авах гэрээ байгуулна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа /ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. Ерөнхий зүйл</b>								
<b>ТӨӨЗ 1.1</b>	Захиалагч нь: <b>Төрийн худалдан авах ажиллагааны газар</b>								
<b>ТӨӨЗ 1.1</b>	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: <b>Тендер шалгаруулалтын нэр:</b> “Төрийн байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай оффисын техник хэрэгслийг ерөнхий гэрээгээр худалдан авах” <b>Тендер шалгаруулалтын дугаар:</b> ТХААГ/202311161								
<b>ТӨӨЗ 1.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <table border="1"><thead><tr><th>№</th><th>Багцын нэр</th></tr></thead><tbody><tr><td>Багц 1</td><td>Компьютер /All-in-One/</td></tr><tr><td>Багц 2</td><td>Компьютер /2 in 1/</td></tr><tr><td>Багц 3</td><td>Компьютер /2 in 1/</td></tr></tbody></table>	№	Багцын нэр	Багц 1	Компьютер /All-in-One/	Багц 2	Компьютер /2 in 1/	Багц 3	Компьютер /2 in 1/
№	Багцын нэр								
Багц 1	Компьютер /All-in-One/								
Багц 2	Компьютер /2 in 1/								
Багц 3	Компьютер /2 in 1/								
<b>ТӨӨЗ 1.6</b>	Мэргэжлийн байгууллага нь уг бараа нийлүүлэх эсхүл үйлчилгээ үзүүлэх <b>хамгийн багадаа 1 буюу түүнээс дээш</b> тооны нийлүүлэгч, эсхүл үйлчилгээ үзүүлэгч шалгаруулж болно.								
<b>ТӨӨЗ 1.7</b>	Шалгарсан тендерт оролцогчидтой <b>2 жил</b> хугацаатай гэрээ байгуулна.								
<b>ТӨӨЗ 2.1</b>	<b>Санхүүжилтийн эх үүсвэр нь:</b> Улсын төсөв								
<b>ТӨӨЗ 4.2.2</b>	Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй ба Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар мэдээллийг шалгана.								
<b>ТӨӨЗ 4.3</b>	Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн ТӨӨЗ-ын 4.2.1-4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж ирүүлнэ.								
	<b>Б. Тендерийн баримт бичиг</b>								
<b>ТӨӨЗ 8.1</b>	<b>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар:</b> Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө байна. Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> )-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим систем дэх тендерийн урилга хэсгийн тодруулгын мэдээллийг байнга шалгаж байхыг зөвлөж байна.								
	<b>В. Тендер бэлтгэх</b>								
<b>ТӨӨЗ 11.1</b>	Тендерийн хэл нь: Монгол хэл дээр байна.								
<b>ТӨӨЗ 12.1 (в)</b>	Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг МАЯГТ № ТШМ 1-2 маягтын дагуу гаргаж ирүүлнэ. <b>Жич:</b> Тендерийн маягтад гарын үсэг зурж буй этгээд нь тус компанийн төлөөлөх эрх бүхий этгээд байгаа тохиолдолд итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.								

<p>ТОӨЗ 12.1 (е)</p>	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>• Тендерийн маягтыг ТББ-т заасан МАЯГТ №:ТШМ-1-ийн дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ. Уг маягтад тухайн бүтээгдэхүүний <b>нэгж үнийг</b> бөглөх бөгөөд <b>цахим системд тээврийн зардал орсон нэгж үнээр үнийн саналыг оруулна</b>. Нэгж үнээр санал ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</li><li>• Үнийн хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. МАЯГТ №:ТШМ-2А, 2Б, 2В-ийн аль тохирохыг сонгох. Тендерт оролцогч нь тухайн санал болгож буй барааны өртгийн задаргааг ирүүлнэ.</li><li>• Тендерт оролцогч худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ээр өөрийн эрхээр нэвтэрч тендерийн нээлт хийх өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд уг хүсэлтийг Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагааг цахимаар илгээдэг болохыг анхаарна уу. Энэхүү тодорхойлолтоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтад заасан нөхцөл байдал үүссэн эсэхийг магадалж үзнэ.</li><li>• Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан нэвтэрч тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ. Жич: Дээрх 2 лавлагаа авах зааварчилгаатай <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</li><li>• Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: <b>Шаардлагатай.</b></li><li>• Татварын тодорхойлолт, татвар төлөлтийн талаар лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлнэ. Оролцогч тендер нээх өдрийн байдлаар татварын ямар нэгэн өргүй байх шаардлагатай,</li><li>• Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, төлбөргүй тухай тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана. /Тендерт оролцогчийн ирүүлсэн татвар, нийгмийн даатгалын тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй./</li><li>• Харьяа татварын байгууллага, нийгмийн даатгалын хэлтэс, харилцагч банк, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг тус тус ирүүлнэ.</li><li>• Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл, өр төлбөргүй тухай тодорхойлолт ирүүлэх.</li><li>• Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ.</li><li>• Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</li><li>• Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх тухай баталгааны мэдэгдэл ирүүлнэ.</li></ul>
----------------------	---

	<ul style="list-style-type: none"> <li>• Тендерийн хэл нь Монгол хэл тул тендерийн материалд хавсарган ирүүлэх гадаад хэл дээрх материалыг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.</li> <li>• Олон улсын чанарын стандартыг хангасныг гэрчлэх сертификаттай эсэх.</li> <li>• Ерөнхий гэрээний хүчинтэй хугацаанд нийлүүлэх барааны үйлдлийн систем, CPU, RAM-ны сүүлийн хувилбарыг нийлүүлэх тухай албан мэдэгдэл ирүүлнэ.</li> </ul> <p><b>Дээрх шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</b></p>												
<p><b>ТӨӨЗ 14.1</b></p>	<p>Худалдан авах бараа, үйлчилгээний нэгж үнийн дээд хязгаар дараах байдалтай байна.</p> <table border="1" data-bbox="464 573 1398 741"> <thead> <tr> <th>№</th> <th>Багцын нэр</th> <th>Нэгж үнэ /төгрөг/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Багц 1</td> <td>Компьютер /All-in-One/</td> <td>7,250,000.0</td> </tr> <tr> <td>Багц 2</td> <td>Компьютер /2 in 1/</td> <td>8,000,000.0</td> </tr> <tr> <td>Багц 3</td> <td>Компьютер /2 in 1/</td> <td>5,500,000.0</td> </tr> </tbody> </table>	№	Багцын нэр	Нэгж үнэ /төгрөг/	Багц 1	Компьютер /All-in-One/	7,250,000.0	Багц 2	Компьютер /2 in 1/	8,000,000.0	Багц 3	Компьютер /2 in 1/	5,500,000.0
№	Багцын нэр	Нэгж үнэ /төгрөг/											
Багц 1	Компьютер /All-in-One/	7,250,000.0											
Багц 2	Компьютер /2 in 1/	8,000,000.0											
Багц 3	Компьютер /2 in 1/	5,500,000.0											
<p><b>ТӨӨЗ 14.5</b></p>	<p>Олон улсын худалдааны нөхцөл- <b>“Incoterms 2010”</b></p>												
<p><b>ТӨӨЗ 14.10 (б) (1) болон (б) (3)</b></p>	<p>Бараа хүргэгдэх газар: Захиалгын хуудсанд заасан хаяг байна.</p>												
<p><b>ТӨӨЗ 14.10 (б) (1)</b></p>	<p>Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТӨӨЗ-ны 15.9. (б). (1) дэх хэсэгт заасан CIF үнэ байна. Энэ үнэнд НӨАТ, даатгал, татвар, сургалт, суурилуулалт болон эцсийн цэг хүртэлх бусад бүх зардлууд багтсан байна.</p>												
<p><b>ТӨӨЗ 14.11</b></p>	<p>Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад суурь үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд тохируулна. Суурь үнэ огцом өөрчлөгдсөн гэдэгт дараах нөхцөлүүдийг аль нэгийг ойлгоно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тендер зарласан өдрийн Монгол банкны ханш 10 буюу түүнээс дээш хувиар валютын ханш (ам.доллар, БНХАУ-ын юань, Евро гэх мэт...) өөрчлөгдсөн тохиолдолд /Үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээний валютыг, үндэслэж үнийн тохируулгыг хийнэ.</li> <li>2. Холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт орсноос шалтгаалан бүтээгдэхүүнд ноогдох татвар, хураамжийн хэмжээ 10 буюу түүнээс дээш хувиар өөрчлөгдсөн тохиолдолд;</li> </ol> <p>Үнийн тохируулга хийх нөхцөл</p> $P_1 = P_0 \left[ a + \frac{bL_1}{L_0} + \frac{cM_1}{M_0} \right] - P_0$ $a + b + c = 1$ <p> <math>P_1</math> – үнийн тохируулга  <math>P_0</math> - гэрээний үндсэн үнэ  a - гэрээний үнэд шингэсэн ашиг, захиргааны зардлын тогтмол дүн.  b - гэрээний үнэд эзлэх ажиллах хүчний хувь  c - гэрээний үнэд эзлэх эцсийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэдэг бол зардлын хувь  <math>L_0, L_1</math> – ажиллах хүчний суурь өдрийн болон тохируулах өдрийн индекс  <math>M_0, M_1</math>- валютын ханшны суурь өдрийн болон тохируулах өдрийн индекс </p>												

	Тендерт оролцогч нь тухайн санал болгож буй барааны өртгийн задаргаа (a,b,c)-г ирүүлнэ. Ирүүлээгүй тохиолдолд тохируулга хийхгүй.												
<b>ТӨӨЗ 15.1</b>	Тендерийн валют: <b>Төгрөг байна</b>												
<b>ТӨӨЗ 16.1 (а)</b>	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн гэрчилгээ ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана.												
<b>ТӨӨЗ 16.1 (б)</b>	Тухайн бараа, үйлчилгээнд шаардлагатай тусгай зөвшөөрөл: <b>“Шаардлагагүй”</b>												
<b>ТӨӨЗ 17.1 (а)</b>	Барааны хувьд үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: <b>“Шаардлагатай”</b> <b>Албан ёсны үйлдвэрлэгч эсвэл гэрээт борлуулагчийн зөвшөөрөлтэй.</b>												
<b>ТӨӨЗ 17.1 (б)</b>	Гэрээг гүйцэтгэхэд: <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Шаардлагатай ажилтны тоо</th> <th>Мэргэжил, Мэргэжлээрээ ажилласан жил</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Мэдээлэл технологийн инженер</td> <td>1</td> <td>Бакалавр буюу түүнээс дээш, 3 болон түүнээс дээш жил</td> </tr> </tbody> </table> <p><i>Мэдээлэл технологийн инженер нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байна. Үүнд:</i></p> <p>Дээрх инженер, техникийн ажилтнуудын жагсаалтыг ирүүлнэ, тухайн төсөл, арга хэмжээнд ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байх бөгөөд тэдгээрийн ажлын туршлагыг ажилтан тус бүрээр ирүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>Дээрх инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ. Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БЕГ-ын Цахим шилжилт нэгдсэн статистикийн газарт хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.</li> <li>“Дипломын мэдээллийг /E-Mongolia/ системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <a href="https://bit.ly/3J1QmHZ">https://bit.ly/3J1QmHZ</a></li> </ol> <p>Дээрх инженер, техникийн ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэлийг 2023 оны 8, 9, 10 дугаар саруудад тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”- ээр дамжуулан шалгах тул НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй.</p>	№	Албан тушаал	Шаардлагатай ажилтны тоо	Мэргэжил, Мэргэжлээрээ ажилласан жил	1	Мэдээлэл технологийн инженер	1	Бакалавр буюу түүнээс дээш, 3 болон түүнээс дээш жил				
	№	Албан тушаал	Шаардлагатай ажилтны тоо	Мэргэжил, Мэргэжлээрээ ажилласан жил									
1	Мэдээлэл технологийн инженер	1	Бакалавр буюу түүнээс дээш, 3 болон түүнээс дээш жил										
<b>ТӨӨЗ 17.1 (в)</b>	<b>Ижил төстэй гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:</b> Сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хуулбар, тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх захиалагчийн тодорхойлолтын хамт ирүүлэх. Багц тус бүр дээр сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилд дараах үнийн дүнтэй ижил төстэй барааг нийлүүлсэн байх. Үүнд: Ижил төстэй ажилд тухайн тоног төхөөрөмж болон түүнтэй дүйцэхүйц бараа нийлүүлсэн туршлагыг тооцно. <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Багцын нэр</th> <th>Ижил төстэй ажлын гэрээний дүн /төгрөг/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Багц 1</td> <td>Компьютер /All-in-One/</td> <td>108,750,000.0</td> </tr> <tr> <td>Багц 2</td> <td>Компьютер /2 in 1/</td> <td>120,000,000.0</td> </tr> <tr> <td>Багц 3</td> <td>Компьютер /2 in 1/</td> <td>82,500,000.0</td> </tr> </tbody> </table>	№	Багцын нэр	Ижил төстэй ажлын гэрээний дүн /төгрөг/	Багц 1	Компьютер /All-in-One/	108,750,000.0	Багц 2	Компьютер /2 in 1/	120,000,000.0	Багц 3	Компьютер /2 in 1/	82,500,000.0
№	Багцын нэр	Ижил төстэй ажлын гэрээний дүн /төгрөг/											
Багц 1	Компьютер /All-in-One/	108,750,000.0											
Багц 2	Компьютер /2 in 1/	120,000,000.0											
Багц 3	Компьютер /2 in 1/	82,500,000.0											

<p><b>ТӨӨЗ 17.1 (г)</b></p>	<p>Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: <b>“Шаардлагатай”</b> Баталгаат хугацаанд засвар, үйлчилгээг хариуцна.          -Барааг нийлүүлсний дараах байнгын болон урсгал үйлчилгээний (засвар) хуваарийг бэлтгэж ирүүлнэ.          -Баталгаат хугацаа нь <b>1 жил</b> байх бөгөөд энэ хугацаанд тохируулах, зүгшрүүлэх үйлчилгээг бүрэн үзүүлж ажиллахыг албан бичгээр баталгаажуулан мэдэгдэх шаардлагатай.          -Тухайн нийлүүлэх бараа бүтээгдэхүүний засвар үйлчилгээний төвтэй байх ба нотлох баримт ирүүлэх шаардлагатай. Хэрэв тухайн засвар үйлчилгээний төв оролцогчийн өөрийн эзэмшлийн байх тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг ирүүлнэ. Түрээсийн гэрээ, болон нотлох зургийн хамт ирүүлнэ.</p>												
<p><b>ТӨӨЗ 17.2 (а)</b></p>	<p>Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: <b>“Шаардана”</b>          Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2020, 2021, 2022 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын сүүлийн 3 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p>												
<p><b>ТӨӨЗ 17.2 (а)</b></p>	<p><b>Борлуулалтын хэмжээ:</b> Сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын дундаж нь багц тус бүрд дараах дүнгээс багагүй байна. Үүнд:</p> <table border="1" data-bbox="464 898 1398 1093"> <thead> <tr> <th>№</th> <th>Багцын нэр</th> <th>Борлуулалтын хэмжээ /төгрөг/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Багц 1</td> <td>Компьютер /All-in-One/</td> <td>108,750,000.0</td> </tr> <tr> <td>Багц 2</td> <td>Компьютер /2 in 1/</td> <td>120,000,000.0</td> </tr> <tr> <td>Багц 3</td> <td>Компьютер /2 in 1/</td> <td>82,500,000.0</td> </tr> </tbody> </table>	№	Багцын нэр	Борлуулалтын хэмжээ /төгрөг/	Багц 1	Компьютер /All-in-One/	108,750,000.0	Багц 2	Компьютер /2 in 1/	120,000,000.0	Багц 3	Компьютер /2 in 1/	82,500,000.0
№	Багцын нэр	Борлуулалтын хэмжээ /төгрөг/											
Багц 1	Компьютер /All-in-One/	108,750,000.0											
Багц 2	Компьютер /2 in 1/	120,000,000.0											
Багц 3	Компьютер /2 in 1/	82,500,000.0											
<p><b>ТӨӨЗ 17.2 (б)</b></p>	<p>Тухайн чиглэлээр ажилласан байх жилийн тоо: <b>3 жилээс багагүй.</b></p>												
<p><b>ТӨӨЗ 17.2 (г)</b></p>	<p><b>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:</b> Багц тус бүрд дараах дүнгээс багагүй байна. Үүнд:</p> <table border="1" data-bbox="464 1211 1398 1402"> <thead> <tr> <th>№</th> <th>Багцын нэр</th> <th>Багц тус бүрд шаардах дүн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Багц 1</td> <td>Компьютер /All-in-One/</td> <td>108,750,000.0</td> </tr> <tr> <td>Багц 2</td> <td>Компьютер /2 in 1/</td> <td>120,000,000.0</td> </tr> <tr> <td>Багц 3</td> <td>Компьютер /2 in 1/</td> <td>82,500,000.0</td> </tr> </tbody> </table>	№	Багцын нэр	Багц тус бүрд шаардах дүн	Багц 1	Компьютер /All-in-One/	108,750,000.0	Багц 2	Компьютер /2 in 1/	120,000,000.0	Багц 3	Компьютер /2 in 1/	82,500,000.0
№	Багцын нэр	Багц тус бүрд шаардах дүн											
Багц 1	Компьютер /All-in-One/	108,750,000.0											
Багц 2	Компьютер /2 in 1/	120,000,000.0											
Багц 3	Компьютер /2 in 1/	82,500,000.0											
<p><b>ТӨӨЗ 17.4</b></p>	<p>Дотоодын давуу эрхийн зөрүү: <b>“тооцно.”</b></p>												
<p><b>ТӨӨЗ 18.1(б)</b></p>	<p>Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан үйлдвэрлэгчийн каталог ирүүлэх, (Каталог дээрээс санал болгож буй бараа түүний үзүүлэлтийг ялган тодруулж ирүүлнэ)</p>												
<p><b>ТӨӨЗ 19.1</b></p>	<p>Тендер нээснээс хойш <b>30</b> хоногийн туршид хүчинтэй байна.</p>												
<p><b>ТӨӨЗ 20.2</b></p>	<p>Тендерт оролцогч төсвийн хөрөнгөөр худалдан авах аливаа тендер шалгаруулалтад оролцох тендерт оролцогчийн эрхийг 1 хүртэл жилийн хугацаанд хасахыг хүлээн зөвшөөрсөн тухай Тендерийн баталгааны мэдэгдэлд гарын үсэг зурж, тендерийн баримт бичгийн гуравдугаар бүлэг дэх Маягт №:ТШМ-3А-ын дагуу ирүүлнэ. <b>Уг мэдэгдлийг ирүүлээгүй тохиолдолд ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно.</b></p>												
<p><b>Г. Тендер ирүүлэх</b></p>													
<p><b>ТӨӨЗ 23.1 (а)</b></p>	<p>Тендерийн өмнөх уулзалтыг зохион байгуулах эсэх: “Үгүй”          Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p>												



<p><b>ТӨӨЗ 23.1 (б)</b></p>	<p><b>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</b>  <b>Огноо: 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр</b>  <b>Цаг: 14 цаг 00 минут</b>  Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</p>
	<p align="center"><b>Д. Тендерийг нээх, үнэлэх</b></p>
<p><b>ТӨӨЗ 26.1</b></p>	<p><b>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв.</b>  Үүнд: Төрийн худалдан авах ажиллагааны газар  <b>Байшин, гудамжны нэр:</b> 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө-16А, Засгийн газрын IX байр, Төрийн худалдан авах ажиллагааны газар  <b>Аймаг, хот:</b> Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  <b>Улс:</b> Монгол Улс  <b>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</b>  <b>Огноо: 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдөр</b>  <b>Цаг: 14 цаг 30 минут</b></p>
	<p align="center"><b>Е. Гэрээ байгуулах эрх олгох</b></p>
<p><b>ТӨӨЗ 38.2</b></p>	<p>Тендерт шалгарсан оролцогч нь гэрээний маягттай уншиж танилцан гарын үсэг зурж баталгаажуулан ажлын 5 хоногт Захиалагчид хүргүүлнэ.</p>
<p><b>ТӨӨЗ 40.3</b></p>	<p>Хоёрдугаар шатны шалгаруулалт нь <b>үнийн санал авах</b> аргын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ээр зохион байгуулагдана.</p>

**ГУРАВДУГААР БҮЛЭГ**  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН МАЯГТ**

**МАЯГТ №: ТШМ-1А**

**ТЕНДЕРИЙН МАЯГТ**

Бараа нийлүүлэх тендер

**[огноо]**

(Мэргэжлийн байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, **[тендерт оролцогчийн нэрийг оруул]**, энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн **[бараа болон бусад үйлчилгээний нэр, тендерийн дугаарыг оруул]**-г тендерийн баримт бичигт заасан Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд дараах үнээр нийлүүлэхээр санал болгож байна.

№	Тээвэрлэлтийн зардал орсон нэгж үнэ /төгрөг/	Тээвэрлэлтийн зардал ороогүй нэгж үнэ /төгрөг/
1	<b>/Үнийг тоо болон үсгээр бичих/</b>	<b>/Үнийг тоо болон үсгээр бичих/</b>
2		

2. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд Мэргэжлийн байгууллагатай Ерөнхий гэрээ байгуулж, цахим дэлгүүрт барааг байршуулан, тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны ажиллагаанд оролцохыг үүгээр зөвшөөрч байна.
3. Захиалагч цахим дэлгүүрт байршуулсан манай барааг худалдан авах тохиолдолд гэрээнд заасан барааг захиалга ирүүлснээс хойш **[моо]** хоногийн дотор нийлүүлнэ.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс **[моо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, түүнийг дагалдах бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.
6. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн гарын үсэг: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал : \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_

## ТЕНДЕРИЙН МАЯГТ

Үйлчилгээ үзүүлэх тендер

[огноо]

(Мэргэжлийн байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэрийг оруул], танай гаргасан тендерийн баримт бичгийг судалж үзээд [үйлчилгээний нэр ба тендерийн дугаарыг оруул]-ыг энэ тендерийн баримт бичигт заасан гэрээний нөхцөл, үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт, зураг болон энэ тендертэй хамт санал болгож буй үйл ажиллагааны хуваарийн дагуу Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд дараах үнээр гүйцэтгэхээр санал болгож байна.

№	Тээвэрлэлтийн зардал орсон нэгж үнэ /төгрөг/	Тээвэрлэлтийн зардал ороогүй нэгж үнэ /төгрөг/
1	/Үнийг тоо болон үсгээр бичих/	/Үнийг тоо болон үсгээр бичих/
2		

2. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд Мэргэжлийн байгууллагатай Ерөнхий гэрээ байгуулж, цахим дэлгүүрт үйлчилгээг байршуулан, тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны ажиллагаанд оролцохыг үүгээр зөвшөөрч байна.
3. Захиалагч цахим дэлгүүрт байршуулсан манай үйлчилгээг худалдан авах тохиолдолд гэрээнд заасан үйлчилгээг захиалга ирүүлснээс хойш [тоо] хоногийн дотор гүйцэтгэнэ.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс [тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Бид, энэхүү тендер шалгаруулалтаар үзүүлэх үйлчилгээ, түүнийг дагалдах бараа, материал, тоног төхөөрөмжийн ажлын даалгавар болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.
6. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн гарын үсэг: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал : \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_



**МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН  
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

(А ангилал)

Огноо: \_\_\_\_\_  
Тендерийн дугаар: \_\_\_\_\_  
Хуудасны \_\_\_\_ -ын \_\_\_\_\_ дугаар \_\_\_\_

ТӨӨЗ-ны 15-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9
Нэр төрөл	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг болон эд анги	EXW нэгж үнэ	Нэр төрөл бүрийн EXWбүгд үнэ (4x5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТӨӨЗ-ны 14.9.(а).(3)-д шаардсан бол)	Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд болон бусад үйлчилгээний өртгийн 6-р баганад заасан үнэд эзлэх хувь	ТӨӨЗ-ны 14.9(а).(2)-д заасан гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж
<b>Тендерийн нийт үнэ (10)</b>								

Тендерт оролцогчийн нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРЖ ИРЭХ  
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

(Б ангилал)

Огноо: \_\_\_\_\_  
Тендерийн дугаар: \_\_\_\_\_  
Хуудасны \_\_\_\_ -ын \_\_\_\_ дугаар \_\_\_\_

ТӨӨЗ-ны 15-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9
Нэр төрөл №	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг	ТӨӨЗ-ны 15.9 (б) (1)-д заасан СИФ эсхүл СИП нэгж үнэ	Нэр төрөл бүрийн СИФ эсхүл СИП нийт үнэ (4 x 5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТӨӨЗ-ны 14.9(б).(3)-д шаардсан бол)	ТӨӨЗ-ны 14.9(б).(2)-д зааснаар гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрлийн нийт дүн (6 + 7+8)
<b>Тендерийн нийт дүн (9)</b>								

Тендэрт оролцогчийн нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРУУЛЖ ИРСЭН  
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

(В ангилал)

Огноо: \_\_\_\_\_  
Тендерийн дугаар: \_\_\_\_\_  
Хуудасны \_\_\_\_ -ын \_\_\_\_ дугаар \_\_\_\_

ТООЗ-ны 15-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Нэр төрөл №	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Инкотермд тусгасны дагуу хүргэх огноо	Тоо ширхэг	ТООЗ-ны 14.9 (в) (1)-д заасан урьд нь төлсөн болон төлөх гаалийн татвар хураамж болон импортын татварыг оруулсан нэгж үнэ	ТООЗ-ны 14.9(в).(2)-д заасан нэр төрөл бүрд төлсөн гаалийн болон импортын татвар хураамж [нотлох бичиг баримтыг үндэслэнэ]	ТООЗ-ны 14.9 (в) (3)-д заасны дагуу нэгж үнэ (гаалийн татвар хураамж болон импортын татварыг хассан) (6 – 7)	ТООЗ-ны 14.9 (в) (3)-д заасны дагуу нэгж үнэ (гаалийн болон импортын татварыг хассан) нэр төрөл бүрийн үнэ	ТООЗ-ны 14.9 (в) (3) (9=8x5)-д заасны дагуу гаалийн болон импортын татварыг хассан нэр төрөл бүрийн үнэ (ТООЗ-ны 14.9(в) (5)-д шаардсан бол)	Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (9+10+11)
Тендерийн нийт үнэ (12)											

Тендерт оролцогчийн нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

**ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МЭДЭГДЭЛ**

*Энэхүү маягтыг тендерийн хамт ирүүлнэ.*

**[огноо]**

(Мэргэжлийн байгууллагын нэр)-ын дарга .....танаа

**[Тендерт оролцогчийн нэр]** (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь Ерөнхий гэрээгээр**[Тендер шалгаруулалтын нэр]**“**бараа нийлүүлэхээр” эсхүл “үйлчилгээ үзүүлэхээр” аль нэгийг сонго**] тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү мэдэгдлээр **[мэргэжлийн байгууллагын нэр]** (цаашид “Мэргэжлийн байгууллага” гэх)-ийн өмнө дараах үүрэг хүлээхийг зөвшөөрч байна.

Төсвийн хөрөнгөөр худалдан авах аливаа тендер шалгаруулалтад оролцох тендерт оролцогчийн эрхийг дараах нөхцөлийн аль нэг нь үүссэн тохиолдолд**[ТШӨХ-ийн ТӨӨЗ 20.2 дахь хэсэгт заасан тоог оруул]** хүртэл жилийн хугацаанд хасахыг хүлээн зөвшөөрч, мэдэгдэл гаргаж байна. Үүнд:

- (1) тендерт оролцогч тендер хүчинтэй байх хугацаанд саналаа буцаан авах, өөрчлөх,
- (2) гэрээ байгуулах эрх олгосны дараа гэрээнд гарын үсэг зурахгүй байх,
- (3) тендерийн баримт бичигт заасан хугацаанаас өмнө маягт №:ТШМ-3Б “Эрх хязгаарлахыг зөвшөөрсөн мэдэгдэл” ирүүлээгүй,
- (4) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Тендерт оролцогчийн нэр: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн гарын үсэг: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал : \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_



## ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МЭДЭГДЭЛ

Энэхүү маягтыг гэрээ байгуулах эрх олгосны дараа гэрээ байгуулахын өмнө ирүүлнэ.

[огноо]

(Мэргэжлийн байгууллагын нэр)-ын дарга .....танаа

**[Тендерт оролцогчийн нэр]** (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь Ерөнхий гэрээгээр **[Тендер шалгаруулалтын нэр]** [“бараа нийлүүлэхээр” эсхүл “үйлчилгээ үзүүлэхээр” аль нэгийг сонго] тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү мэдэгдлээр **[мэргэжлийн байгууллагын нэр]** (цаашид “Мэргэжлийн байгууллага” гэх)-ийн өмнө дараах үүрэг хүлээхийг зөвшөөрч байна.

Төсвийн хөрөнгөөр худалдан авах аливаа тендер шалгаруулалтад оролцох тендерт оролцогчийн эрхийг дараах нөхцөлийн аль нэг нь үүссэн тохиолдолд **[ТШӨХ-ийн ТӨӨЗ 39.2 дахь хэсэгт заасан тоог оруул]** хүртэл жилийн хугацаанд хасахыг хүлээн зөвшөөрч, мэдэгдэл гаргаж байна. Үүнд:

- (1) ерөнхий гэрээний хоёрдугаар шатны ажиллагаанд оролцохоос нэгээс дээш удаа татгалзсан,
- (2) цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээ нь тендерт санал болгосон барааны техникийн тодорхойлолт, үйлчилгээний ажлын даалгавраас зөрсөн,
- (3) гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзсан.

Тендерт оролцогчийн нэр: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн гарын үсэг: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал : \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_

### Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн итгэмжлэл

*[Тендерт оролцогч энд заасан зааврын дагуу үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчаар энэ маягыг бөглүүлсэн байна.Энэхүү итгэмжлэлийг үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн албан бланкан дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна.ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]*

Огноо: \_\_\_\_\_

Тендер шалгаруулалтын дугаар: \_\_\_\_\_

(Мэргэжлийн байгууллагын нэр)-ын дарга .....танаа

Бид, **[оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүтэн хаяг]**-д байршилтай **[оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүрэн нэр]** нь**[оруул: үйлдвэрлэдэг/ борлуулдаг барааны төрөл]**-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/борлуулдаг бөгөөд, үүгээр **[оруул: тендерт оролцогчийн бүтэн нэр]** компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан **[оруул: барааны нэр ба товч тодорхойлолт]**, барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийн Ерөнхий гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Гэрээний ерөнхий нөхцөлийн 16-д заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн нэр: \_\_\_\_\_

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: \_\_\_\_\_

Албан тушаал, нэр: \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_





## Санхүүгийн чадавх

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүрийг оролцуулан ТООЗ-ны 17.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг хангаж буйг харуулсан санхүүгийн мэдээллийг ирүүлнэ. Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр энэ маягтын дагуу өөрийн холбогдох мэдээллийг ирүүлнэ. Шаардлагатай бол банкны мэдээллийн хүснэгтийг тус тусдаа бөглөнө.

Банк	Банкны нэр	
	Банкны хаяг	
	Утас	Холбоо барих ажилтны нэр, албан тушаал
	Факс	Телекс

Сүүлийн (ТШӨХ-д заасан тоо) хүртэлх жилийн хугацааны нийт хөрөнгө болон эх үүсвэрийг төгрөгөөр (хөрвүүлэх ханш нь тухайн жил бүрийн эцсийн байдлаар мөрдөгдөж байсан Монгол банкны зарласан ханш байна) илэрхийлнэ.

Санхүүгийн мэдээлэл /сая/	Сүүлийн (ТШӨХ-д заасан тоо) хүртэлх жилийн хугацаанд					Төлөвлөсөн: Дараагийн 2 жилийн хугацаанд	
	5	4	3	2	1	1	2
1. Нийт хөрөнгө							
2. Эргэлтийн хөрөнгө							
3. Нийт өглөг							
4. Эргэлтийн өглөг							
5. Татварын өмнөх ашиг							
6. Татварын дараах ашиг							

Санал болгож буй санхүүгийн эх үүсвэр буюу ТООЗ-ны 17.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг ханган гэрээг гүйцэтгэх явцад хүрэлцэхүйц эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэйг харуулсан хөрвөх хөрөнгө, зээл авах боломж буюу зээлжих баталгаажсан эрх болон бусад санхүүгийн хэрэгслийг тодорхойлно.

Эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад эх үүсвэр	Дүн
1.	
2.	
3.	
4.	

## Ажиллах хүчний чадавх

Тендерт оролцогчийн нэр
-------------------------

Тендерт оролцогч нь гэрээний удирдлага болон хэрэгжилтийг хариуцан ажиллахтай холбогдох ур чадвар, мэргэжлийн шаардлагыг хангасан, хамгийн багадаа 2 хүний нэрийг албан тушаал тус бүрд дэвшүүлнэ.Нэр дэвшигч бүрийн ажлын туршлагын талаарх мэдээллийг тус тусад нь гаргаж ирүүлнэ.

Тендерт оролцогч нь гэрээг удирдах, хэрэгжилтийн зохион байгуулах хувилбарт нэр дэвшигчийн ажлын туршлага, ур чадварын талаарх мэдээллийг мөн ирүүлнэ.

1.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
2.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
3.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
4.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр

**ХОЁРДУГААР ХЭСЭГ**

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

**БАРАА НИЙЛҮҮЛЭЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

**АГУУЛГА**

- 1. БАРААНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**
- 2. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР**
- 3. ЗУРАГ ТӨСӨЛ**
- 4. ШАЛГАЛТ БОЛОН ТУРШИЛТ**

## **1. Техникийн тодорхойлолт бэлтгэх санамж**

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай байгаа бараа болон холбогдох үйлчилгээний техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлоход оршдог.

Ойлгомжтой бөгөөд сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендер оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд л худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийг үнэлэх үнэлгээ зөв явагдана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, орчин үеийн загварын, мөн зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардвал зохино.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн барааны стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа, материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

### **Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал**

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал, тэдгээрийг турших стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй дүйцэх, эсхүл түүнээс илүү чанартай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандарт, кодыг хүлээн зөвшөөрнө.

Барааны тэмдэг, каталогийн дугаарыг заасан шаардлагыг аль болох тавихгүй байна. Зайлшгүй шаардлагын улмаас эдгээрийг хэрэглэх бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэж нэмж заана.

Шаардлагатай тохиолдолд захиалагч зураг болон ажлын талбайн төлөвлөгөөг тендерийн баримт бичгийн хамт тендер оролцогчдод өгнө. Үүнд мөн тендер оролцогч зураг болон загварыг тендертэй хамт, эсхүл гэрээний хэрэгжилтийн явцад захиалагчид урьдчилан хянуулах зорилгоор ирүүлэхээр зааж болно.

Хэрвээ захиалагч техникийн тодорхойлолтын хураангуйг гаргуулахаар бол дараах хүснэгтийг ашиглан шаардлагатай мэдээллийг тусгаж өгнө. Тендер оролцогч санал болгож буй бараа, үйлчилгээ нь уг шаардлагад нийцэж байгаа эсэхийг ижил хүснэгтээр харуулна.

**Техникийн тодорхойлолтын хураангуй.** Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.



**Техникийн тодорхойлолтыг хавсарган хүргүүлэв.**

## АЖЛЫН ДААЛГАВАР

Үйлчилгээний тодорхойлолт

Үзүүлэх үйлчилгээний хүрээнд хийгдэх ажил бүрийг дуусгахаар төлөвлөсөн хугацаа, тэдгээр ажлыг гүйцэтгэх байршил, захиалагчийн баталж хийлгэх тусгай ажлууд гэх мэтээр үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, танилцуулгыг бичих.

Төлбөрийн хуваарь ба Тайлан

Төлбөр хийх бүх үе шатууд, үзүүлэх үйлчилгээний эсхүл гаргах тайлангийн хэлбэр, давтамж болон агуулга, тэдгээрийг хүлээж авах хүмүүс, ирүүлэх хугацаа гэх мэтийг жагсааж бичнэ. Хэрэв тухайн үйлчилгээнд тайлан ирүүлэх шаардлагагүй бол энэ хэсэгт "тайланг ирүүлэх шаардлагагүй" гэж бичнэ.

Голлох боловсон хүчин ба туслан гүйцэтгэгчид:

- Жагсаалтад: В-1 Албан тушаал [хэрэв байгаа бол нэрийг нь], ажлын дэлгэрэнгүй тодорхойлолт болон тухайн ажилтанд тавигдах хамгийн бага чадварын шаардлага, мөн тухайн ажлын байр бүрд шаардагдах хүн саруудыг заах .
- В-2 В-1д заасны нэгэн адил тухайн үйлчилгээнд ажиллах голлох мэргэжилтнүүдэд тавигдах шаардлагыг заах
- В-3 Зөвшөөрөгдсөн Туслан гүйцэтгэгчдийн (хэрэв байгаа бол) жагсаалт. Тэдний боловсон хүчинд тавигдах В-1 эсхүл В-2 –т заасантай ижил мэдээллийг заах

Захиалагчийн үзүүлэх үйлчилгээ болон техник хэрэгсэл:

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ БА ЗУРАГ

(а) Үйлчилгээний тодорхойлолтод өгөх тайлбар

*Үйлчилгээг аль болох хүрэх үр дүн, үйл ажиллагаа, гүйцэтгэлийн чанарын талаас нь тодорхойлж бичих*

(б) Зурагт өгөх тайлбар

*Энд зургуудыг жагсааж оруул. Үндсэн зургаас гадна гүйцэтгэлийн диаграм болон муруй гэх мэт бусад зургууд, талбайн план, газарзүйн байрлал болон бусад хавсаргагдах материалууд байна.*

## 2. Зураг, төсөл

Тендерийн баримт бичигт зураг, төсөл ирүүлэх шаардлагатай бол дараах хүснэгтийг ашиглана.

<b>Зураг төслийн жагсаалт</b>		
<b>Зураг, төслийн дугаар.</b>	<b>Зураг төслийн нэр</b>	<b>Зориулалт</b>

## 3. Шалгалт, туршилт

Мэргэжлийн байгууллага шаардлагатай бол нийлүүлэгдэх бараа, үйлчилгээний хувьд хийгдсэн байх ёстой үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлэхийг тендерт оролцогчоос шаардаж болно.

## ГУРАВДУГААР ХЭСЭГ

### ТАВДУГААР БҮЛЭГ

#### БАРАА НИЙЛҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

##### ГАРЧИГ

1. Нэр томьёо
2. Тайлбар
3. Гэрээнд баримтлах хууль
4. Гэрээнд ашиглах хэл, хэмжих нэгж
5. Харилцах журам
6. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах
7. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
8. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах
9. Барааны гарал үүслийн улс
10. Шалгалт, туршилт
11. Баглаа боодол
12. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт
13. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх
14. Гүйцэтгэлийн баталгаа
15. Даатгал
16. Чанарын баталгаа, баталгаат засвар
17. Төлбөрийн нөхцөл, нэхэмжлэл
18. Үнэ
19. Хүргэлтийн хугацаа, хүргэлтийн хуваарийг сунгах
20. Торгууль
21. Гэрээ цуцлах
22. Маргааныг шийдвэрлэх
23. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
24. Гэрээний үүргийг шилжүүлэх
25. Татвар, хураамж
26. Үүргийн гүйцэтгэл
27. Гэрээний зүйл хадгалагдах
28. Байгаль орчны хамгаалалт
29. Мэдээллийн үнэн зөв байдал
30. Сонирхлын зөрчил

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томьёо 1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- (а) “гэрээ” гэж Мэргэжлийн байгууллага, ерөнхий гэрээний тендер шалгаруулалтад шаардлагад нийцсэн гэж үнэлэгдсэн гурав ба түүнээс дээш нийлүүлэгчийн хооронд ТШӨХ-д заасан хугацаанд давтамжтайгаар бараа нийлүүлэх ерөнхий гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
  - (б) “гэрээний үнэ” гэж нийлүүлэгчийн тендерт санал болгож буй тухайн барааны нэгж үнэ буюу цахим дэлгүүрт байршуулсан барааны үнэ байна.
  - (в) “бараа” гэж нийлүүлэгчээс захиалагчид ерөнхий гэрээний дагуу их хэмжээгээр нийлүүлэх физик шинж чанар бүхий материал, түүхий эд, барилгын материал, тоног төхөөрөмж, сэлбэг, хэрэгсэл, эмийн хэрэгсэл, химийн бүтээгдэхүүн, түлш, тээврийн хэрэгсэл, хөдөө аж ахуй болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хүнс болон бусад төрлийн бүтээгдэхүүнийг хэлнэ.
  - (г) “дагалдах үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.
  - (д) “цахим дэлгүүр” гэж ерөнхий гэрээ байгуулан худалдан авах бараа, үйлчилгээний мэдээлэл бүхий цахим худалдан авах ажиллагааны системийн бүрэлдэхүүн хэсгийг хэлнэ.
  - (е) “мэргэжлийн байгууллага” гэж Ерөнхий гэрээгээр барааг худалдан авах ажлыг зохион байгуулж, гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж буй байгууллагыг хэлнэ.
  - (ё) “захиалагч” гэж цахим дэлгүүрээс барааг худалдан авах гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
  - (ж) “нийлүүлэгч” гэж гэрээнд заасан барааг цахим дэлгүүрээр дамжуулан нийлүүлэх этгээдийг хэлнэ.
  - (з) “хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
  - (и) “хүргэлтийн хугацаа” гэж Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээний хүрээнд бараа нийлүүлэх болон гүйцэтгэх (суурилуулж, үйл ажиллагаа явуулахад бэлэн болгох) хугацааг хэлнэ.

(й) “хүргэлтийн газар” гэж гэрээний тусгай нөхцөлд эсхүл захиалгын хуудаст тодорхойлсон бараа хүргэгдэх газрыг, хэрэв уг газрыг тусгайлан заагаагүй бол захиалагчийн зөвшөөрсөн газрыг хэлнэ.

(к) “захиалгын хуудас” гэж цахим дэлгүүрээс худалдан авах барааны тоо хэмжээ, хүргэх газар, ажил гүйцэтгэх хуваарийг заасан баримт бичгийг хэлнэ.

(л) “Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ” гэж Захиалагч, цахим дэлгүүрт бүртгэгдсэн нийлүүлэгчтэй тухайн барааг худалдан авахаар хэлэлцэн, тохиролцож байгуулсан гэрээг хэлнэ.

- |  |   |
|--|---|
| <b>2. Тайлбар</b>                          | 2.1. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН) болон гэрээний тусгай нөхцөл (ГТН) хоорондоо зөрчилдсөн тохиолдолд гэрээний тусгай нөхцөлийг баримтална.   |
| <b>3. Гэрээнд баримтлах хууль</b>          | 3.1. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д өөрөөр тусгайлан заагаагүй бол энэхүү гэрээ түүгээр зохицуулагдах талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний хэрэгжилт, гэрээний хүчин төгөлдөр байх (хүчин төгөлдөр бус байх), гэрээний гүйцэтгэл болон гэрээнээс үүсэх аливаа асуудлыг Монгол улсын хуулиар зохицуулна.  |
| <b>4. Гэрээнд ашиглах хэл, хэмжих нэгж</b> | 4.1. Энэ гэрээ нь ГТН-д тусгайлан заасан хэлээр бичигдэнэ. Энэ нь гэрээний агуулга, тайлбартай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд ашиглах хэл байна.<br>4.2. ГЕН-ийн 4.1 дэх хэсэгт заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна.<br>4.3. Энэхүү гэрээ, гэрээгээр нийлүүлэх бараанд олон улсын нэгжийн систем буюу “СИ” системийг ашиглана.   |
| <b>5. Харилцах журам</b>                   | 5.1. Энэхүү гэрээнд холбогдох асуудлаар талууд зөвхөн бичгээр харилцах бөгөөд талуудын томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгчид хаягласан хүргэлт, гэрээний тусгай нөхцөлд заасан хаягаар дээрх этгээдэд илгээсэн э-шуудан, факс болон бүртгэгдсэн шуудангийн хаягаар илгээснээс хойш ажлын 3 хоног өнгөрсөн бол бичгэн хэлбэрээр харилцсанд тооцно.<br>5.2. Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтын аргын дагуу нийлүүлэгчээс цахим худалдан авах ажиллагааны систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> )-д ирүүлсэн саналыг бичгэн хэлбэрээр харилцсанд тооцно.<br>5.3. Нийлүүлэгч нь шаардлагатай тохиолдолд ГЕН-ийн 5.1, 5.2 дахь хэсэгт заасан бичгэн хэлбэрээр харилцсан аливаа үйлдлийг хүлээн авагч авсан болохыг нотлох баримтыг өөрөө бүрдүүлнэ. |

- |   |   |
|---|---|
| <b>6. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах</b> | <p>6.1. Нийлүүлэгч нь Мэргэжлийн байгууллага бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж Мэргэжлийн байгууллагын өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задалж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.</p> <p>6.2. Мэргэжлийн байгууллага бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч ГЕН-ийн 6.1 дэх хэсэгт дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.</p> <p>6.3. ГЕН-ийн 6.1 дэх хэсэгт дурдсан гэрээнээс бусад баримт бичиг Мэргэжлийн байгууллагын өмч хэвээр үлдэх ба хэрэв Мэргэжлийн байгууллага хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) Мэргэжлийн байгууллагад буцааж өгнө.</p> <p>6.4. Мэргэжлийн байгууллага нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.</p> |
| <b>7. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах</b>                                   | <p>7.1. Энэхүү гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Хуульд заасан үндэслэлээр гэрээнд нэмэлт өөрчлөлт хийх бол бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.</p>   |
| <b>8. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах</b>                                  | <p>8.1. Тендерт ирүүлснээс өөр этгээдээр туслан гүйцэтгүүлэхийг хориглоно.</p> <p>8.2. Нийлүүлэгч гэрээг хэрэгжүүлэхдээ сонгосон аливаа туслан гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан ажил үүрэгт ногдох гэрээний холбогдох нөхцөл, болзлыг бүрэн биелүүлэхийг батламжилна.</p> <p>8.3. Туслан гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үүрэг, хариуцлагаас нийлүүлэгч нь чөлөөлөгдөхгүй.</p>   |
| <b>9. Барааны гарал үүслийн улс</b>   | <p>9.1. Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.</p> <p>9.2. Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.</p>  |



## 10. Шалгалт, туршилт

- 10.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг буюу бараа, түүний бүрэлдэхүүн хэсэг, материал, үйлдвэрлэл нь чанар болон тоо хэмжээний шаардлагад нийцэж буйг баталгаажуулах зорилгоор Мэргэжлийн байгууллага, захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. ГТН-д эсвэл техникийн тодорхойлолтод Мэргэжлийн байгууллага, захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Мэргэжлийн байгууллага, Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)-ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
- 10.2. Шалгалт, туршилт нь барааг үйлдвэрлэсэн, угсарсан, бэлтгэсэн, бараа хүргэх газар, эцсийн цэг болон ГТН-д заасан газарт байж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд Мэргэжлийн байгууллага, захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана.
- 10.3. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд Мэргэжлийн байгууллага, захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээг нэн даруй авна.
- 10.4. Хэрвээ шалгалт, туршилтын хариуг мэргэжлийн байгууллага, захиалагч, нийлүүлэгч хүлээн зөвшөөрөхгүй бол энэ тухай холбогдох нотлох баримтын хамт шалгалт, туршилтын хариуг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор гэрээний бусад талуудад бичгээр мэдэгдэж, талуудын харилцан зөвшөөрсөн шинжээч томилж, шалгалт, туршилт дахин хийлгэх хүсэлтийг мэргэжлийн байгууллагад гаргана. Мэргэжлийн байгууллага шалгалт, туршилтыг зохион байгуулж, шинжээчийн дүгнэлтийг хүлээн авч, бусад талуудад мэдэгдэнэ. Шинжээчийн дүгнэлт нь эцсийнх байна. Дахин шалгалт, туршилт хийх зардлыг уг хүсэлтийг гаргасан тал бүрэн хариуцна.
- 10.5. Барааг тээвэрлэхээс өмнө Мэргэжлийн байгууллага, захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох Мэргэжлийн байгууллага, захиалагчийн эрхийг хөндөхгүй.
- 10.6. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.

**11. Баглаа  
боодол**

- 11.1. Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тунадас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.
- 11.2. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН эсхүл Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээнд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.

**12. Барааны  
нийлүүлэлт  
ба баримт  
бичгийн  
бүрдүүлэлт**

- 12.1. Нийлүүлэгч нь захиалагчаас ирүүлсэн захиалгын хуудасны дагуу техникийн тодорхойлолтод нийцсэн барааг нийлүүлнэ. Техникийн тодорхойлолтод нийцсэн, цахим дэлгүүрт байршуулснаас өөр бараа нийлүүлж үл болно.
- 12.2. Захиалагчаас ирүүлсэн захиалгын хуудасны хүрээнд Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтад шалгарсан нийлүүлэгчтэй Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ байгуулагдсаны дараа нийлүүлэгч бараа нийлүүлэлтийг эхлүүлнэ.
- 12.3. Нийлүүлэгч нь гэрээнд зааснаас өөр эсхүл чанарын болон иж бүрдлийн доголдолтой бараа нийлүүлсэн бол захиалагч энэ талаар мэргэжлийн байгууллага болон нийлүүлэгчид нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ. Хэрэв захиалагчийн мэдэгдэлд дурдсан хугацаанд нийлүүлэгч нь гэрээнд зааснаас өөр эсхүл чанарын болон иж бүрдлийн доголдолтой барааг сольж өгөөгүй тохиолдолд захиалагч нь цахим дэлгүүр дэх гуравдагч этгээдээс тухайн барааг шууд сонголт хийж худалдан авна. Энэ тохиолдолд захиалагч гэрээнд заасан барааг гуравдагч этгээдээс худалдан авахад гарсан барааны үнийн зөрүү болон бусад нэмэлт өртгийг нийлүүлэгч нөхөн төлнө.
- 12.4. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд эсхүл Ерөнхий гэрээний дагуу худалдан авах тухай гэрээнд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.
- 12.5. Гэрээнд хэрэглэсэн CIP /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.

- 13. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх**
- 13.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг Мэргэжлийн байгууллага, захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
- 14. Гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэл**
- 14.1. Нийлүүлэгч нь гэрээний хүчинтэй хугацааны туршид гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэх, гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулан төсвийн хөрөнгөөр худалдан авах аливаа тендер шалгаруулалтад оролцох тендерт оролцогчийн эрхийг тодорхой хугацааны туршид хасахыг хүлээн зөвшөөрсөн тухай гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэлд гарын үсэг зурна.
- 14.2. Нийлүүлэгч ГЕН-ийн 14.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээг цуцлах болон тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд орох үндэслэл болно.
- 15. Даатгал**
- 15.1. ГТН-д тусгайлан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг ГТН-д заасан хэлбэрээр инкотермсийн нөхцөлийн дагуу даатгуулна.
- 16. Чанарын баталгаа, баталгаат засвар**
- 16.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.
- 16.2. ГТН-д өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.
- 16.3. Захиалагч энэхүү баталгаатай холбогдох гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
- 16.4. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
- 16.5. Захиалагч нь ГЕН-ийн 16.2 заасныг үл харгалзан, ГЕН-ийн 16.4-т заасны дагуу гэмтэл согогийг арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана.

- 16.6. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу захиалагчийн заасан хугацаанд түүнийг арилгаагүй тохиолдолд гарах хохирол, үр дагаврыг үл маргах зарчмаар нийлүүлэгч өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна.
- 17. Төлбөрийн нөхцөл, нэхэмжлэл**
- 17.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН эсхүл Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээнд дурдана.
- 17.2. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон ГЕН-ийн 12дугаар зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 17.3. ГТН эсхүл Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээнд өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийн нэхэмжлэх хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 17.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.
- 18. Үнэ**
- 18.1. Гэрээний дагуу хүргэсэн барааны үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцож, цахим худалдан авах ажиллагааны системд цахим хэлбэрээр ирүүлсэн нэгж үнийг баримтална.
- 18.2. Энэхүү гэрээ байгуулагдсанаас хойш холбогдох хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас цахим дэлгүүрт байршуулсан гэрээний үнэ, бараа нийлүүлэлтийн хугацаа өөрчлөгдөхөд хүрвэл нийлүүлэгч энэ талаар мэдсэнээс хойш 14 хоногийн дотор Мэргэжлийн байгууллагад гэрээний үнэ өөрчлөгдөх болсон талаарх дэлгэрэнгүй үндэслэл, нотлох баримтын хамт бичгээр ирүүлнэ. Мэргэжлийн байгууллага гэрээний үнэ өөрчлөгдөх нь үндэслэлтэй байна гэж үзвэл уг өөрчлөлтийг цахим дэлгүүрт байршуулна.
- 18.3. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэн бол гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөхийг нийлүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу мэргэжлийн байгууллага шийдвэрлэнэ.
- 18.4. ГЕН-ийн 18.2, 18.3 дахь хэсэгт тус тус зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөхийг зөвшөөрөхгүй.
- 19. Хүргэлтийн хугацаа, хүргэлтийн хуваарийг сунгах**
- 19.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээнд заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 19.2. Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:

- (а) Мэргэжлийн байгууллага, захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу Мэргэжлийн байгууллага, захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно);
- (б) Мэргэжлийн байгууллага, захиалагч гэрээний үүргээ зохих хугацаанд биелүүлээгүй бол;
- (в) Нийлүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаанаар барааны нийлүүлэлт хойшилсон бол;
- (г) ГЕН-ийн 23 дугаар зүйлд заасан гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүсвэл.

19.3. Нийлүүлэгч хугацаа хоцрохоос урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.

19.4. Гүйцэтгэгч ГЕН-ийн 19.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болох тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд ГЕН-ийн 19.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.

## 20. Алданги

20.1. Энэхүү гэрээний 24 дүгээр зүйлд өөрөөр заагаагүй бол Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорсон бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн гэрээний тусгай нөхцөлд заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтэрч болохгүй.

20.2. Алданги дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллага захиалагч, нийлүүлэгчид (а) ГЕН-ийн 21.1 дэх хэсгийн дагуу Ерөнхий гэрээг цуцлах, (б) нийлүүлэгчийн өртгөөр барааг нийлүүлэх тухай бичгээр мэдэгдэнэ.

## 21. Гэрээ цуцлах

21.1. Мэргэжлийн байгууллага дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:

- (а) нийлүүлэгч нь Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтад 1-ээс дээш удаа оролцоогүй;
- (б) нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй тухай захиалагчаас Мэргэжлийн байгууллагад 2 буюу түүнээс дээш удаа гомдол ирсэн бөгөөд Захиалагчийн гомдол үндэслэлтэй болох нь тогтоогдсон;

- (в) нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй, техникийн тодорхойлолтын шаардлага хангасан боловч тээвэрлэлт, хүргэлтийн явцад эвдэрч, гэмтсэн, чанарын доголдолтой талаарх захиалагчаас ирүүлсэн мэдэгдэлд заасан хугацаанд нийлүүлэгч алдаагаа залруулаагүй;
- (г) Нийлүүлэгч нь аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсхүл ГЕН-ийн 19 дүгээр зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;
- (д) гэрээнд заасан бусад нөхцөл.

21.2. Нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлига, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдсоныг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоосон бол Мэргэжлийн байгууллага түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.

21.3. Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол Мэргэжлийн байгууллага нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ Мэргэжлийн байгууллага нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь Мэргэжлийн байгууллага, захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрхийг хөндөхгүй.

21.4. Гэрээ цуцлах мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланд хэрэгжүүлнэ. Үүнд:

- (а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл
- (б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.

## **22. Маргааныг шийдвэрлэх**

22.1. Мэргэжлийн байгууллага, Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцөл болон хэлэлцээгээр шийдэхийг хичээнэ.

22.2. Дээрх хэлэлцээ 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал ГТН-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.

- 23. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал**
- 23.1. Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс Мэргэжлийн байгууллага, захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол ГЕН-ийн 19 дүгээр зүйлийн дагуу түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.
- 23.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар Мэргэжлийн байгууллага болон захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
- 24. Гэрээний үүргийг шилжүүлэх**
- 24.1. Ямар ч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 25. Татвар, хураамж**
- 25.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оногдуулдаг бүх төрлийн татвар хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 26. Үүргийн гүйцэтгэл**
- 26.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ гүйцэтгэхдээ холбогдох хууль, тогтоомж, журам, заавар, техникийн тодорхойлолтыг дагаж мөрдөнө.
- 26.2. Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.
- 27. Гэрээний зүйл хадгалагдах**
- 27.1. Энэхүү гэрээний зарим зүйл, хэсэг, заалт нь хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон нь гэрээг бүхэлд нь хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохгүй бөгөөд хүчин төгөлдөр бус гэж тооцогдсоноос бусад зүйл, хэсэг, заалт нь хуулийн хүчинтэй байна.
- 28. Байгаль орчны хамгаалалт**
- 28.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ гүйцэтгэхдээ байгаль орчны холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 29. Мэдээллийн үнэн зөв байдал**
- 29.1. Нийлүүлэгч нь цахим дэлгүүрт байршуулсан барааны мэдээлэл, нийлүүлэгчээс томилсон гэрээний хугацаанд түүнийг төлөөлөх эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл (нэр, утас, э.шуудан гэх мэт), нийлүүлэгчийн аж ахуйн нэгжийн бүртгэл, хаяг, холбогдох утас, факс, э.шуудан зэрэг мэдээллийн үнэн зөвийг хариуцна.
- 29.2. Нийлүүлэгч нь ГЕН-ийн 29.1 дэх хэсэгт заасан холбогдох мэдээлэлд орсон өөрчлөлтийг нэн даруй мэргэжлийн байгууллагад мэдэгдэж засварлана.
- 29.3. Нийлүүлэгч холбогдох мэдээллээ шинэчлээгүйн улмаас цахим дэлгүүрт байршуулсан мэдээлэлд үндэслэн захиалагч худалдан авалтын захиалга хийсэнтэй холбоотой үүсэх аливаа нэмэлт зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

**30. Сонирхлын  
зөрчил**

30.1. Нийлүүлэгчид төлөх нийт төлбөр нь зөвхөн энэ гэрээний дагуу худалдан авах гэрээтэй холбогдож төлөгдөх бараа нийлүүлсний төлбөр байх бөгөөд нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу, эсхүл гэрээний үүргээ биелүүлэхэд хэрэгжүүлсэн аливаа үйл ажиллагаатай холбогдуулж өөрт ашигтайгаар урамшуулал, хөнгөлөлт, болон ижил төстэй төлбөрийг бусад этгээдээс авахыг үл зөвшөөрнө. Нийлүүлэгч нь мөн өөрийн ажилтан болон туслан гүйцэтгэгчид, холбогдох бусад хамтрагчдыг дээрхтэй ижил төстэй нэмэлт төлбөр авахгүй байх явдлыг хангахын төлөө ажиллана.



## ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### ГАРЧИГ

1. Нэр томьёо
2. Тайлбар
3. Гэрээнд баримтлах хууль
4. Гэрээнд ашиглах хэл
5. Харилцах журам
6. Байршил
7. Төлөөлөх эрх бүхий этгээд
8. Гэрээний хяналт, шалгалт
9. Татвар, хураамж
10. Гэрээ хүчин төгөлдөр болох
11. Дуусгахаар төлөвлөсөн өдөр
12. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
13. Гэрээг цуцлах
14. Гэрээ цуцлагдсан үед хийгдэх төлбөр
15. Үйлчилгээ үзүүлэгчийн эрх үүрэг
16. Сонирхлын зөрчил
17. Нууцлал
18. Үйлчилгээ үзүүлэгчийн хариуцах даатгал
19. Тайлагнах
20. Үйлчилгээ үзүүлэгчийн бэлтгэсэн баримт бичгүүд нь захиалагчийн өмч байх
21. Алданги
22. Гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэл
23. Боловсон хүчин
24. Туслалцаа
25. Үйлчилгээ ба техник хэрэгсэл
26. Үйлчилгээний төлбөр
27. Гэрээний үнэ
28. Төлбөрийн нөхцөл, нэхэмжлэл
29. Хугацаа хоцорсон төлбөрт төлөх алданги
30. Ажил-өдрүүд
31. Зөрчил гологдол илрүүлэх
32. Зөрчил, гологдол арилгах
33. Маргааныг шийдвэрлэх
34. Гэрээний зүйл хадгалагдах
35. Байгаль орчны хамгаалалт
36. Мэдээллийн үнэн зөв байдал

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### 1. Нэр томьёо

1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

(а) “Гэрээ” гэж Мэргэжлийн байгууллага, ерөнхий гэрээний тендер шалгаруулалтад шаардлагад нийцсэн гэж үнэлэгдсэн гурав ба түүнээс дээш үйлчилгээ үзүүлэгчийн хооронд ТШӨХ-д заасан хугацаанд давтамжтайгаар үйлчилгээ үзүүлэх ерөнхий гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.

(б) “Гэрээний үнэ” гэж үйлчилгээ үзүүлэгчийн тендерт санал болгож буй тухайн үйлчилгээний нэгж үнэ буюу цахим дэлгүүрт байршуулсан үйлчилгээний үнэ байна.

(в) “Үйлчилгээ” гэж үйлчилгээ үзүүлэгчээс захиалагчид ерөнхий гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний тодорхойлолтод заасан оюуны болон зөвлөх шинж чанартай эсхүл бусад төрлийн үйлчилгээг хэлнэ.

(г) “Дагалдах бараа” гэж гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэхэд дагалдах бараа, материал, тоног төхөөрөмжийг хэлнэ.

(д) “Цахим дэлгүүр” гэж ерөнхий гэрээ байгуулан худалдан авах үйлчилгээ, дагалдах бараа, материал, тоног төхөөрөмжийн мэдээлэл бүхий цахим худалдан авах ажиллагааны системийн бүрэлдэхүүн хэсгийг хэлнэ.

(е) “Мэргэжлийн байгууллага” гэж Ерөнхий гэрээгээр үйлчилгээ худалдан авах ажлыг зохион байгуулж, гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж буй байгууллагыг хэлнэ.

(ё) “Захиалагч” гэж цахим дэлгүүрээс үйлчилгээ худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.

(ж) “Үйлчилгээ үзүүлэгч” гэдэг нь гэрээнд заасан үйлчилгээг цахим дэлгүүрээр дамжуулан гүйцэтгэх этгээдийг;

(з) “Үйл ажиллагааны хуваарь” гэж гүйцэтгэгчээс үзүүлэх бүх үйлчилгээний нэр төрлийг үнэлж ирүүлсэн жагсаалтыг;

(и) “Ажил-өдөр” гэж үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох удирдлагын болон материалын зардлаас гадна түүний ажиллах хүч болон тоног төхөөрөмжийн ажилласан хугацаанаас хамааран төлөгдөх төлөвлөөгүй зардлыг;

(й) “Гишүүн” гэж үйлчилгээ үзүүлэх этгээд нь нэгээс олон байгууллагууд хамтран түншлэл болсон тохиолдолд түншлэлийн аливаа нэг байгууллагыг; “Гишүүд” гэж тэдгээр бүх байгууллагыг; “Төлөөлөх эрх бүхий гишүүн” гэж харин энэхүү гэрээний дагуу захиалагчийн өмнө үйлчилгээ үзүүлэгчийн

хүлээх бүх эрх, үүрэг хариуцлагыг тэдний өмнөөс төлөөлөхөөр гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон байгууллагыг“;

(к) “Тал” гэж Мэргэжлийн байгууллага, үйлчилгээ үзүүлэгч этгээдийг, харин “Талууд” гэж эдгээрийг хоёуланг нь ойлгоно;

(л) “Боловсон хүчин” гэж тухайн үйлчилгээг эсхүл түүний зарим хэсгийн ажлыг гүйцэтгүүлэхээр үйлчилгээ үзүүлэгчийн эсхүл аливаа туслан гүйцэтгэгчийн томилсон ажилтныг;

(м) “Дотоодын валют” гэж төгрөгийг;

(н) “Гадаад валют” гэж төгрөгөөс өөр валютыг;

(о) “Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт” гэж Үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн тендерийн бүрэлдэхүүнд багтсан үйлчилгээний тодорхойлолтыг;

(ө) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний зарим хэсгийг туслан гүйцэтгүүлэхээр Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээ байгуулсан гэрээнд нэр нь дурдагдсан этгээдийг;

(п) “захиалгын хуудас” гэж цахим дэлгүүрээс худалдан авах үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, гүйцэтгэх хуваарийг заасан баримт бичгийг хэлнэ.

(р) “Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ” гэж Захиалагч, цахим дэлгүүрт бүртгэгдсэн үйлчилгээ үзүүлэгчтэй тухайн үйлчилгээг худалдан авахаар хэлэлцэн, тохиролцож байгуулсан гэрээг хэлнэ.

- |                                   |  |
|-----------------------------------|--|
| <b>2. Тайлбар</b>                 | 2.1. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН) болон гэрээний тусгай нөхцөл (ГТН) хоорондоо зөрчилдсөн тохиолдолд гэрээний тусгай нөхцөлийг баримтална.  |
| <b>3. Гэрээнд баримтлах хууль</b> | 3.1. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д өөрөөр тусгайлан заагаагүй бол энэхүү гэрээ түүгээр зохицуулагдах талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээний хэрэгжилт, гэрээний хүчин төгөлдөр байх (хүчин төгөлдөр бус байх), гэрээний гүйцэтгэл болон гэрээнээс үүсэх аливаа асуудлыг Монгол улсын хуулиар зохицуулна.                                   |
| <b>4. Гэрээнд ашиглах хэл</b>     | 4.1. Энэ гэрээ нь ГТН-д тусгайлан заасан хэлээр бичигдэнэ. Энэ нь гэрээний агуулга, тайлбартай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд ашиглах хэл байна.<br>4.2. ГЕН-ийн 4.1 дэх хэсэгт заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг үйлчилгээ үзүүлэгч хариуцна.  |
| <b>5. Харилцах журам</b>          | 5.1. Энэхүү гэрээнд холбогдох асуудлаар талууд зөвхөн бичгээр харилцах бөгөөд талуудын томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгчид хаягласан хүргэлт, гэрээний тусгай нөхцөлд заасан хаягаар дээрх этгээдэд илгээсэн э-шуудан, факс болон бүртгэгдсэн шуудангийн хаягаар илгээснээс хойш ажлын 3 хоног өнгөрсөн бол бичгэн хэлбэрээр харилцсанд тооцно. |

- 5.2. Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтын аргын дагуу үйлчилгээ үзүүлэгчээс цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д ирүүлсэн саналыг бичгэн хэлбэрээр харилцсанд тооцно.
- 5.3. Үйлчилгээ үзүүлэгч нь шаардлагатай тохиолдол ГЕН-ийн 5.1, 5.2 дахь хэсэгт заасан бичгэн хэлбэрээр харилцсан аливаа үйлдлийг хүлээн авагч авсан болохыг нотлох баримтыг өөрөө бүрдүүлнэ.
- 6. Байршил** 6.1. Үйлчилгээ нь ГТН-д эсхүл захиалгын хуудаст тодорхойлсон газар хийгдэх ба тодорхой ажлын байршил тусгайлан заагдаагүй бол захиалагчийн баталсан байршилд хийгдэнэ.
- 7. Төлөөлөх эрх бүхий этгээд** 7.1. Энэ гэрээний дагуу мэргэжлийн байгууллага, үйлчилгээ үзүүлэгчийн хэрэгжүүлэх шаардлагатай буюу зөвшөөрөгдсөн аливаа арга хэмжээ болон боловсруулах шаардлагатай аливаа баримт бичгийг зөвхөн ГТН-д заасан албан тушаалтнууд гүйцэтгэж эсхүл боловсруулж болно.
- 8. Гэрээний хяналт шалгалт** 8.1. Үйлчилгээ үзүүлэгч нь Мэргэжлийн байгууллага болон Захиалагчийн шаардсанаар үйлчилгээний хэрэгжилт, үр дүнтэй холбоотой аливаа бүртгэл, тайланг шалгуулах, түүний томилсон аудитораар үр дүнгийн хяналт хийлгэхийг зөвшөөрөх үүрэгтэй.
- 9. Татвар, хураамж** 9.1. Үйлчилгээ үзүүлэгч, туслан гүйцэтгэгчид болон тэдний ажилтан холбогдох хууль, тогтоомжийн дагуу ногдох аливаа татвар, хураамжийг төлөх үүрэгтэй бөгөөд энэ дүнг гэрээний үнэд багтсан гэж үзнэ.
- 10. Гэрээ хүчин төгөлдөр болох** 10.1. Энэхүү гэрээ нь хоёр тал гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхсүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 11. Дуусгахаар төлөвлөсөн өдөр** 11.1. ГЕН-ийн 13 дугаар зүйлд заасны дагуу хугацаанаас нь өмнө гэрээг цуцалснаас бусад тохиолдолд тухайн Үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагаагаа ГТН-д тодорхойлсон дуусгахаар төлөвлөсөн өдөрт дуусгана. Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь дуусгахаар төлөвлөсөн өдөр гэхэд үйл ажиллагаагаа дуусгаагүй бол 24 дүгээр зүйлд заасны дагуу алданги төлнө.
- 12. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал** 12.1. Иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс Мэргэжлийн байгууллага, захиалагч, эсхүл үйлчилгээ үзүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол үйл ажиллагааг явуулах боломжгүй байсан тэр хугацаагаар уг талын гэрээ гүйцэтгэх хугацааг сунгана.

12.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар Мэргэжлийн байгууллага болон захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

### 13. Гэрээ цуцлах

13.1. Мэргэжлийн байгууллага дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчид бичгээр гэрээг цуцлах тухай 30-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:

(а) Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцдаа гаргасан алдааг захиалагч илрүүлж захиалагчийн бичгээр гаргасан мэдэгдэлд 30 хоногоос илүүгээр заасан хугацаанд багтаж залруулаагүй бол;

(б) Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон эсхүл дампуурсан бол;

(в) Хэрэв гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөлөөс үүдэн Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн үйлчилгээний үндсэн хэсгийг (30)-аас багагүй хоногийн дотор хийж гүйцэтгэх боломжгүй болсон; эсхүл

(г) Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх болон гэрээ байгуулах эрх олж авах явцдаа авлига, эсхүл залилан мэхлэх үйл ажиллагаанд холбогдсон нь шүүх эсхүл холбогдох байгууллагаар нотлогдсон бол;

(д) Үйлчилгээ үзүүлэгч нь Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтад 1-ээс дээш удаа оролцоогүй;

(е) Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь гэрээг дуусгавар болгох хугацааг хойшлуулснаас болж ГТН болон ГЕН-ийн 21.1-д заасны дагуу захиалагчид төлөгдөх алдангийн дээд хувь хэмжээнд хүрсэн тохиолдолд;

(ё) гэрээнд заасан бусад нөхцөл.

13.2. Үйлчилгээ үзүүлэгч нь доорх нөхцөл байдал үүссэн тохиолдолд 30–аас доошгүй хоногийн өмнө гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Мэргэжлийн байгууллагад бичгээр хүргүүлсний үндсэн дээр гэрээг цуцалж болно. Үүнд:

(а) Хэрэв захиалагч нь энэ гэрээний дагуу төлбөрөө төлөөгүй бөгөөд төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай үйлчилгээ үзүүлэгчийн бичгээр гаргасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш (15) хоногт багтаан ГЕН-ийн 33 дугаар зүйлд заасны дагуу үл маргалдах журмаар төлбөр хийгээгүй бол; эсхүл

(б) Хэрэв Үйлчилгээ үзүүлэгч нь гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөлийн улмаас (30)-аас багагүй

хоногоор үндсэн үйлчилгээг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд.

- 14. Гэрээ цуцлагдсан үед хийгдэх төлбөр**
- 14.1. ГЕН-ийн 13.1, 13.2-т заасан нөхцөлийн дагуу гэрээг цуцлагдсан үед захиалагч дараах төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгчид төлнө:
- (а) Гэрээнд заасан үүргээ гүйцэтгэсэн хугацаанаас үйлчилгээг цуцлах болсон өдөр хүртэлх хугацаанд хангалттай гүйцэтгэсэн ажлын хөлс;
  - (б) ГЕН-ийн 13 дугаар зүйлд заасны дагуу гэрээг цуцалснаас бусад тохиолдолд гэрээ цуцалсантай холбогдож гарсан бодит шууд зардлын нөхөн төлбөр
- 15. Үйлчилгээ үзүүлэгчийн эрх үүрэг**
- 15.1. Үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагааны хуваарь болон техникийн тодорхойлолтод заасны дагуу үйлчилгээг үзүүлэхдээ нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн арга техник болон практик зарчмын дагуу өөрийн үүргийг хэмнэлттэй, үр ашигтай, чармайлт гарган гүйцэтгэх ба сайн удирдлага, зохион байгуулалттайгаар ажиллаж аюулгүй арга хэлбэр, тохиромжит дэвшилтэт технологийг ашиглана. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний эсхүл үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа явуулахдаа захиалагчид ямагт шударга зөвлөгөө өгөх бөгөөд туслан гүйцэтгэгч эсхүл гуравдагч этгээдтэй харилцах аливаа асуудалд хандахдаа ямагт захиалагчийн хууль ёсны эрх сонирхлыг хамгаалж, дэмжиж ажиллана.
- 16. Сонирхлын зөрчил**
- 16.1. Үйлчилгээ үзүүлэгч нь аливаа урамшуулал, хөнгөлөлтөөс ашиг хүртэхгүй байх:  
Үйлчилгээ үзүүлэгчид төлөх үйлчилгээний нийт хөлс нь зөвхөн энэ гэрээ буюу үйлчилгээтэй холбогдож төлөгдөх үйлчилгээ үзүүлсний төлбөр байх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь энэ гэрээний дагуу, эсхүл гэрээний үүргээ биелүүлэхэд хэрэгжүүлсэн аливаа үйл ажиллагаатай холбогдуулж өөрт ашигтайгаар урамшуулал, хөнгөлөлт, болон ижил төстэй төлбөрийг бусад этгээдээс авахыг үл зөвшөөрнө. Үйлчилгээ үзүүлэгч нь мөн өөрийн ажилтан болон туслан гүйцэтгэгчид, холбогдох бусад хамтрагчдыг дээрхтэй ижил төстэй нэмэлт хөлс авахгүй байх явдлыг хангахын төлөө ажиллана.
- 16.2. Үйлчилгээ үзүүлэгч болон түүний хамтрагч нь төсөлд өөр сонирхолтойгоор оролцохгүй байх:  
Үйлчилгээ үзүүлэгч болон түүний хамтрагч, түүнчлэн аливаа туслан гүйцэтгэгч болон түүний хамтрагч нь гэрээг хэрэгжүүлэх хугацаанд болон гэрээний хэрэгжилт дууссанаас хойш энэхүү үйлчилгээ болон үүнтэй нягт холбоотой бусад төслийн бараа, ажил, үйлчилгээ (энэхүү гэрээгээр үзүүлж байгаа үйлчилгээнээс бусад үйлчилгээ)-ний гүйцэтгэгч, нийлүүлэгч байх эрхгүй.
- 16.3. Зөрчилтэй үйл ажиллагаанд оролцохыг хориглох:  
Үйлчилгээ үзүүлэгч эсхүл түүний туслан гүйцэтгэгч эсхүл тэдгээрийн ажилтан дараах үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцохыг хориглоно. Үүнд:
- (а) Гэрээний хэрэгжилтийн хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу гүйцэтгэж буй үйл ажиллагаатай зөрчилдөх аливаа бизнесийн эсхүл мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;

(б) Гэрээний хэрэгжилтийн хугацаанд үйлчилгээ үзүүлэгч эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн зүгээс төрийн албан хаагчийг гэрээний дагуу явуулах аливаа үйл ажиллагааг гүйцэтгэх үндсэн ажилтнаар хөлсөлж ажиллуулах;

(в) Энэхүү гэрээ дууссанаас хойш гэрээний тусгай нөхцөлд заасан бусад үйл ажиллагаа явуулах.

- 17. Нууцлал** 17.1. Үйлчилгээ үзүүлэгч, түүний туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажилтан нь тухайн гэрээ, төсөл, үйлчилгээ болон Захиалагчийн үйл ажиллагаатай холбоотой өмчлөлийн болон нууц мэдээллийг гэрээний хэрэгжилтийн явцад болон гэрээг хэрэгжүүлж дууссанаас хойш (2) жилийн хугацаанд захиалагчийн бичгээр урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.
- 18. Үйлчилгээ үзүүлэгчийн хариуцах даатгал** 18.1. Үйлчилгээ үзүүлэгч нь (а) ГТН-д заасан эрсдэлийн эсрэг захиалагчийн зөвшөөрсөн нөхцөлөөр өөрийн/ байгаа бол туслан гүйцэтгэгчийн зардлаар/ зардлаар даатгуулах бөгөөд (б) захиалагчийн хүсэлтээр даатгуулсан тухай болон даатгалын төлбөр хийсэн талаарх нотлох баримтыг захиалагчид хүргүүлж болно.
- 19. Тайлагнах** 19.1. Үйлчилгээ үзүүлэгч нь Хавсралт В-д тодорхойлсон тайлан, баримт бичгүүдийг уг хавсралтад заасан хугацаанд, заасан маягтаар ирүүлнэ.
- 20. Үйлчилгээ үзүүлэгчийн бэлтгэсэн баримт бичгүүд нь Захиалагчийн өмч байх** 20.1. ГЕН-ийн 19 дүгээр зүйлийн дагуу үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн бүх төлөвлөгөө, зураг, техникийн тодорхойлолт, загвар, тайлан бусад баримт бичиг болон программ хангамж нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээрийг холбогдох бүртгэлийн хамт тухайн гэрээ дуусгавар болохоос эсхүл гэрээний хугацаа дуусахаас өмнө захиалагчид ирүүлэх үүрэгтэй. Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээр баримт бичиг болон программ хангамжийн хуулбарыг авч үлдэж болно. Гэхдээ авч үлдсэн тохиолдолд түүнийг ГТН-д заасан хязгаарлалтын хүрээнд цаашид ашиглаж болно.
- 21. Алданги** 21.1. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний гэрээг дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд ГТН-д заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
- 21.2. Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь Захиалагчийн мэдэгдэлд заасан хугацаанд гаргасан алдаа дутагдлыг арилгаагүй бол үйлчилгээ үзүүлэгч хангалтгүй үр дүнгийн торгууль төлнө. Үйлчилгээ үзүүлэгчийн төлөх торгуулийн хувь хэмжээг ГЕН-ийн 32дугаар зүйлд заасны дагуу алдаа дутагдлыг арилгахад гарах зардлын тодорхой хувиар тооцно.
- 22. Гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэл** 22.1. Нийлүүлэгч нь гэрээний хүчинтэй хугацааны туршид гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэх, гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулан төсвийн хөрөнгөөр худалдан авах аливаа

тендер шалгаруулалтад оролцох тендерт оролцогчийн эрхийг тодорхой хугацааны туршид хасахыг хүлээн зөвшөөрсөн тухай гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэлд гарын үсэг зурна.

22.2. Нийлүүлэгч ГЕН-ийн 22.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээг цуцлах болон тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд орох үндэслэл болно.

**23. Боловсон хүчин**

23.1. Үйлчилгээ үзүүлэгчийн голлох боловсон хүчний албан тушаал, санал болгож буй ажлын байрны тодорхойлолт, чадварын доод шаардлагууд болон үйлчилгээг гүйцэтгэхэд ажиллуулахаар тооцсон хугацаа зэрэг нь Хавсралт В-д тодорхой тусгагдсан. Хавсралт В-д нэр, албан тушаалаар нь жагсааж бичсэн голлох боловсон хүчин болон туслан гүйцэтгэгчдийг Мэргэжлийн байгууллага үүгээр зөвшөөрч байна.

23.2. Мэргэжлийн байгууллага зөвшөөрснөөс бусад тохиолдолд голлох боловсон хүчин/ажилтанд өөрчлөлт хийгдэхгүй. Хэрэв Үйлчилгээ үзүүлэгчээс хамаарахгүй шалтгаанаар голлох боловсон хүчин/ажилтныг солих шаардлагатай гарвал Үйлчилгээ үзүүлэгч нь түүнтэй ур чадвараараа дүйцэхүйц эсхүл түүнээс илүү чадвартай боловсон хүчнийг оронд нь ажиллуулахаар санал болгоно.

23.3. Үйлчилгээ үзүүлэгчийн боловсон хүчин нь (i) эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон болох нь тогтоогдсон, (ii) гэрээний дагуу гүйцэтгэж буй ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн зэргийг Мэргэжлийн байгууллага, Захиалагч мэдсэн бол эдгээр үндэслэлээр тухайн ажилтныг Мэргэжлийн байгууллага, Захиалагчийн хүлээн зөвшөөрөхүйц чадвар, туршлагатай өөр ажилтнаар солиулах хүсэлтийг Үйлчилгээ үзүүлэгчид бичгээр гаргана.

23.4. Боловсон хүчнийг халах эсхүл солих үйл явдалтай холбоотой гарах аливаа нэмэлт зардлыг Үйлчилгээ үзүүлэгч Мэргэжлийн байгууллага, захиалагчаас нэхэмжлэх эрхгүй.

**24. Туслалца а**

24.1. Үйлчилгээ үзүүлэгчид ГТН-д заасан шаардлагатай бүх талын арга хэмжээг захиалагч авч хэрэгжүүлнэ.

**25. Үйлчилгээ ба техник хэрэгсэл**

25.1. Захиалагч нь Үйлчилгээ үзүүлэгчийг худалдан авах гэрээнд дурдсан тоног төхөөрөмж болон үйлчилгээгээр хангах үүрэгтэй.

**26. Үйлчилгээний төлбөр**

26.1. Гэрээний дагуу гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ үйлчилгээ үзүүлэгч нь Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцож, цахим худалдан авах ажиллагааны системд цахим хэлбэрээр ирүүлсэн нэгж үнийг баримтална.

26.2. Энэхүү гэрээ байгуулагдсанаас хойш холбогдох хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас цахим дэлгүүрт байршуулсан гэрээний үнэ, үйл ажиллагааны хуваарийн хугацаа өөрчлөгдөхөд хүрвэл үйлчилгээ үзүүлэгч энэ талаар мэдсэнээс хойш 14 хоногийн дотор Мэргэжлийн байгууллагад гэрээний үнэ өөрчлөгдөх болсон талаарх дэлгэрэнгүй үндэслэл, нотлох баримтын хамт бичгээр ирүүлнэ. Мэргэжлийн байгууллага



гэрээний үнэ өөрчлөгдөх нь үндэслэлтэй байна гэж үзвэл уг өөрчлөлтийг цахим дэлгүүрт байршуулна.

26.3. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэн бол гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөхийг үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу мэргэжлийн байгууллага шийдвэрлэнэ.

26.4. ГЕН-ийн 26.2, 26.3 дахь хэсэгт тус тус зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөхийг зөвшөөрөхгүй.

**27. Гэрээний үнэ**

27.1. Дотоод валютаар төлөгдөх гэрээний үнийг ГТН-д тусгана.

**28. Төлбөрийн нөхцөл, нэхэмжлэл**

28.1. Гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН эсхүл Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээнд дурдана.

28.2. Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон үйл ажиллагааны тайлангийн хамт захиалагчид хүргүүлнэ.

28.3. ГТН эсхүл Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээнд өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийн нэхэмжлэх хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шуурхай хийнэ.

28.4. Гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.

**29. Хугацаа хоцорсон төлбөрт төлөх алданги**

29.1. Хэрэв захиалагч ГТН-д заасан төлбөр хийх хугацаанаас (15) ба түүнээс дээш хоногоор хоцроож төлбөр хийх тохиолдолд хугацаа хоцроосон өдөр бүрт ГТН-д заасан хувь хэмжээгээр тооцож Үйлчилгээ үзүүлэгчид алданги төлнө.

**30. Ажил-өдрүүд**

30.1. Шаардлагатай бол зөвхөн захиалагчийн урьдчилан бичгээр гаргасан зааварчилгааны дагуу бага хэмжээний нэмэлт ажил, үйлчилгээний төлбөрийг төлөхөд Үйлчилгээ үзүүлэгчийн тендерт дурдсан ажил-өдрийн нэгж үнийг ашиглана.

30.2. Үйлчилгээ үзүүлэгч ажил-өдрөөр тооцогдон төлөгдөх бүх ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн талаар захиалагчийн баталсан маягтын дагуу тэмдэглэл хөтөлнө. Бөглөсөн маягтыг ажил үйлчилгээг гүйцэтгэснээс хойш 2 хоногийн дотор багтааж захиалагчаар, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдээр батлуулна.

30.3. Захиалагч 30.2-т дурдсаны дагуу батлуулсан ажил-өдрийн маягтыг үндэслэн ажил-өдрийн төлбөрийг үйлчилгээ үзүүлэгчид төлнө.

**31. Зөрчил гологдол илрүүлэх**

31.1. Мэргэжлийн байгууллага, Захиалагч Үйлчилгээ үзүүлэгчийн ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Ийнхүү шалгах нь

Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Мэргэжлийн байгууллага, Захиалагч зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажил, үйлчилгээнд зөрчил, гологдол хайх, уг үйлчилгээний далд хэсгийг нээх, аль нэг үйлчилгээний туршилт хийхийг Үйлчилгээ үзүүлэгчээс шаардах эрхтэй. Чанарын баталгаат хугацааг ГТН-д тодорхойлсны дагуу байна.

- 32. Зөрчил, гологдол арилгах**
- 32.1. Мэргэжлийн байгууллага, Захиалагч гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг Үйлчилгээ үзүүлэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 32.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Үйлчилгээ үзүүлэгч уг зөрчил, гологдлыг захиалагчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 32.3. Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь Мэргэжлийн байгууллага, Захиалагчийн мэдэгдэлд заасан хугацаанд гаргасан алдаа дутагдлыг арилгаагүй бол Мэргэжлийн байгууллага, Захиалагч зөрчлийг арилгахад гарах зардлыг үнэлж 21 дүгээр зүйлд зааснаар тооцож дутуу гүйцэтгэсэн ажлын торгуулийг ногдуулах бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч уг торгуулийг захиалагчид төлөх үүрэгтэй.
- 33. Маргааныг шийдвэрлэх**
- 33.1. Мэргэжлийн байгууллага, Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбоотой гарах аливаа маргааныг харилцан зөвшилцөж, хэлэлцээгээр шийдвэрлэхийг хичээнэ.
- 33.2. Дээрх хэлэлцээ 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдвэрлэж чадахгүй бол аль ч тал ГТН-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.
- 34. Гэрээний зүйл хадгалагдах**
- 34.1. Энэхүү гэрээний зарим зүйл, хэсэг, заалт нь хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон нь гэрээг бүхэлд нь хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохгүй бөгөөд хүчин төгөлдөр бус гэж тооцогдсоноос бусад зүйл, хэсэг, заалт нь хуулийн хүчинтэй байна.
- 35. Байгаль орчны хамгаалалт**
- 35.1. Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний үүргээ гүйцэтгэхдээ байгаль орчны холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 36. Мэдээллийн үнэн зөв байдал**
- 36.1. Үйлчилгээ үзүүлэгч нь цахим дэлгүүрт байршуулсан үйлчилгээний мэдээлэл, үйлчилгээ үзүүлэгчээс томилсон гэрээний хугацаанд түүнийг төлөөлөх эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл (нэр, утас, э.шуудан гэх мэт), үйлчилгээ үзүүлэгчийн аж ахуйн нэгжийн бүртгэл, хаяг, холбогдох утас, факс, э.шуудан зэрэг мэдээллийн үнэн зөвийг хариуцна.
- 36.2. Үйлчилгээ үзүүлэгч нь ГЕН-ийн 36.1 дэх хэсэгт заасан холбогдох мэдээлэлд орсон өөрчлөлтийг нэн даруй мэргэжлийн байгууллагад мэдэгдэж засварлана.

36.3. Үйлчилгээ үзүүлэгч холбогдох мэдээллээ шинэчлээгүйн улмаас цахим дэлгүүрт байршуулсан мэдээлэлд үндэслэн захиалагч худалдан авалтын захиалга хийсэнтэй холбоотой үүсэх аливаа нэмэлт зардлыг Үйлчилгээ үзүүлэгч бүрэн хариуцна.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ  
ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ  
БАРАА НИЙЛҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ  
ТУСГАЙ НӨХЦӨЛ**

<b>1. Тодорхойлолт (ГЕН - 1)</b>	1.1.(а)	Ерөнхий гэрээний хэрэгжих хугацаа: Энэхүү ерөнхий гэрээ нь гэрээ байгуулсан өдрөөс 2 жил <b>хүчинтэй</b> .
	1.1.(ж)	Захиалагч нь <b>Төрийн худалдан авах ажиллагааны газар</b> Ажлын талбай нь <b>Захиалагчийн хаяг байна</b> .
	1.1 (и)	
<b>2. Шалгалт туршилт (ГЕН - 10)</b>	10.1	[Нийлүүлэх барааны онцлогоос шалтгаалан гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг илүү дэлгэрэнгүй болгож нарийвчлах шаардлага гарч болно. Энд ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
<b>3. Баглаа боодол (ГЕН - 11)</b>	11.1	[Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
<b>4. Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт (ГЕН - 12)</b>	12.1	ГЕН-ийн 12 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: <sup>1</sup>  “Монгол Улсын гаднаас санал болгосон бараа (жишээлбэл СИП):  Нийлүүлэгчбараагтээврийнхэрэгсэлдачсаныдарааэнэтуха йбүрэнмэдээллийг Мэргэжлийн байгууллага, захиалагч болондаатгалынбайгууллагадутсанхолбоогоормэдэгдэнэ. Мэдэгдэлд гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, тээврийн хэрэгслийн нэр, тээврийн баримтын дугаар, ачсан боомт, боомтоос гарах огноо, буулгах боомт зэргийг дурдана. Нийлүүлэгч дараах баримт бичгийг <sup>2</sup> захиалагч болон даатгалын байгууллагад шуудангаар илгээнэ:  1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;  2) барааны багц бүрийн баглаа боодлын жагсаалт;  3) даатгалын гэрчилгээ[үүнийг эхний нийлүүлэлт хийгдэхэд захиалагчид өгөх ба дараагийн захиалгуудад өгөхгүй байж болно];

<sup>1</sup>Эдгээр заалтуудыг зөвхөн жишээ болгож дурдсан / ба олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын мөрддөг жишиг/ тухайн бараа нийлүүлэлтийн онцлогт тохируулан өөрчилж болно.

<sup>2</sup>Инкотермсын аль нөхцөлийг ашиглахаас үүдэн бусад зохих бичиг баримтын нэрийг жагсаана.

- 4) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ[үүнийг эхний нийлүүлэлт хийгдэхэд захиалагчид өгөх ба дараагийн захиалгуудад өгөхгүй байж болно];
- 5) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ[үүнийг эхний нийлүүлэлт хийгдэхэд захиалагчид өгөх ба дараагийн захиалгуудад өгөхгүй байж болно];
- 6) барааны гарал үүслийн гэрчилгээ.[үүнийг эхний нийлүүлэлт хийгдэхэд захиалагчид өгөх ба дараагийн захиалгуудад өгөхгүй байж болно];
- 9.4 Монгол Улсын дотроос санал болгосон бараа (ИКСБ):
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
- 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
- 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
- 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
- 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа нийлүүлэхэд захиалагчид өгнө. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.”
5. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН - 14) 14.1 *Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Тендерт оролцогч төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах аливаа тендер шалгаруулалтад оролцох тендерт оролцогчийн 1 хүртэл жилийн хугацаанд хасахыг хүлээн зөвшөөрсөн тухай Гүйцэтгэлийн баталгааны мэдэгдэл байна.*
6. Баталгаат засвар (ГЕН-16) 16.2 Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: “**Шаардлагатай**” Баталгаат хугацаанд засвар, үйлчилгээг хариуцна.  
Баталгаат хугацаа нь барааг хүлээлгэж өгснөөс хойш эхлэх ба **1 жил** байх бөгөөд энэ хугацаанд тохируулах, зүгшрүүлэх үйлчилгээг бүрэн үзүүлж ажиллана.
7. Төлбөр (ГЕН - 17)
- 17.1 Ерөнхий гэрээний хоёр дугаар шатны сонгон шалгаруулалтын үндэслэж захиалагчтай байгуулсан гэрээнд заасан хугацааны дагуу захиалгын тоо хэмжээгээр барааг 100 хувь бараа нийлүүлж хүлээлцэх актыг захиалагчтай үйлдсэний дараа төлбөрийг барагдуулах нөхцөл үүснэ.
8. Үнэ (ГЕН - 18) 18.1 Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад суурь үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд тохируулна. Суурь үнэ огцом өөрчлөгдсөн гэдэгт дараах нөхцөлүүдийг аль нэгийг ойлгоно. Үүнд:

3. Тендер зарласан өдрийн Монгол банкны ханш 10 буюу түүнээс дээш хувиар валютын ханш (ам.доллар, БНХАУ-ын юань, Еврогэх мэт...) өөрчлөгдсөн тохиолдолд /Үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээний валютыг, үндэслэж үнийн тохируулгыг хийнэ.
4. Холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт орсноос шалтгаалан бүтээгдэхүүнд ноогдох татвар, хураамжийн хэмжээ 10 буюу түүнээс дээш хувиар өөрчлөгдсөн тохиолдолд;

Үнийн тохируулга хийх нөхцөл

$$P_1 = P_0 \left[ a + \frac{bL_1}{L_0} + \frac{cM_1}{M_0} \right] - P_0$$

$$a+b+c = 1$$

$P_1$  – үнийн тохируулга

$P_0$  - гэрээний үндсэн үнэ

$a$  - гэрээний үнэд шингэсэн ашиг, захиргааны зардлын тогтмол дүн.

$b$  - гэрээний үнэд эзлэх ажиллах хүчний хувь

$c$  - гэрээний үнэд эзлэх эцсийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэдэг бол зардлын хувь

$L_0, L_1$  – ажиллах хүчний суурь өдрийн болон тохируулах өдрийн индекс

$M_0, M_1$ - валютын ханшны суурь өдрийн болон тохируулах өдрийн индекс

Тендерт оролцогч нь тухайн санал болгож буй барааны өртгийн задаргаа ( $a, b, c$ )-г ирүүлнэ. Ирүүлээгүй тохиолдолд тохируулга хийхгүй.

9. Алданги оногдуулах (ГЕН - 20) <sup>3</sup>	20.1	Алданги оногдуулах хувь: <b>[moo]</b> Алдангийн нийт дүн: <b>[moo]</b>
10. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 22)	22.1	Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
11. Мэргэжлийн байгууллагын эрх, үүрэг		Гэрээний хүчин төгөлдөр хугацаанд шинээр нийлүүлэгч нэмж оруулж <b>болно</b> .
12. Чанарын баталгааг хангах (ГЕН-16)	16.1	Багцуудад шалгарсан оролцогч тендерт санал болгосон, захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцсэн барааг нийлүүлнэ. Мөн ерөнхий гэрээний хүчинтэй хугацаанд нийлүүлэх барааны үйлдлийн систем, CPU, RAM-ны сүүлийн хувилбарыг нийлүүлнэ.

<sup>3</sup> Монгол Улсын иргэний хууль

## [ДООРХ НӨХЦӨЛҮҮДИЙГ ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛД ЗААЖ ОРУУЛНА]

<b>Урамшуулал</b>	[Гэрээгээр нийлүүлэгдэх барааг хуваариас өмнө хүргэх нь захиалагчид ашигтай бол барааг хуваариас өмнө хүргэсэн тохиолдолд нийлүүлэгчид мөнгөн урамшуулал өгөх тухай нөхцөлийг оруулж болно.]
<b>Хохирлыг барагдуулах</b>	[Тухайн барааны шинж чанарын улмаас ямар нэг алдагдлыг (жишээлбэл бүтээгдэхүүний хариуцлагатай холбогдсон) нөхөх, эсхүл үүрэг хүлээх шаардлага үүсэж болзошгүй тохиолдолд энэ тухай заалтыг ГТН-д заана.]
<b>Сэлбэг</b>	[Энд боломжтой бол захиалагчид шаардлагатай сэлбэг, хэрэгслийн жагсаалтыг, эсхүл захиалагчийг шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангах зорилгоор тэдгээрийг үйлдвэрлэх, нийлүүлэхийг гүйцэтгэгч зөвшөөрөх тухай заалтыг оруулна. Сэлбэгээр хангах үүргийн үргэлжлэх хугацаа, сэлбэг авах тухай захиалагчийн хүсэлтийг нийлүүлэгч хүлээн аваад ямар хугацаанд нийлүүлэх тухай заана.]
<b>Лиценз болон зөвшөөрөл</b>	[Барааг импортлох болон ашиглахад ямар нэг лиценз, зөвшөөрөл шаардагдах бол тус лиценз, зөвшөөрлийг гаргуулах болон холбогдох зардлыг аль тал хариуцах тухай заалтыг оруулна.]
<b>Албан бичиг солилцох</b>	[Захиалагч гэрээний маягтын 4 дүгээр зүйлд заасан мэдэгдлээс бусад албан бичгийг өөр хаягаар хүлээн авах, илгээх хүсэлтэй бол үүнийгээ ГТН-д заана.]

**ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ  
ТУСГАЙ НӨХЦӨЛ**

<b>Гэрээний Ерөнхий нөхцөлийн холбогдох зүйлийн дугаар</b>	<b>Гэрээний ерөнхий нөхцөлийн зүйл, заалтад оруулсан нэмэлт, өөрчлөлт</b>
1.1(в)	Гэрээний нэр нь <i>[Гэрээний нэрийг бич]</i> .
1.1(е)	Мэргэжлийн байгууллага гэж <i>[Мэргэжлийн байгууллагын нэрийг оруул]</i>
1.1(й)	Төлөөлөх эрх бүхий гишүүн нь <i>[Түншлэлийг төлөөлөх эрх бүхий компанийн нэр].]</i>
1.1(м)	Үйлчилгээ үзүүлэгч нь <i>[нэрийг оруул]</i>
1.2	Гэрээний хууль гэж: <i>[Аль улсын хуулиар зохицуулагдахыг бичих]</i>
1.3	Гэрээний хэл гэж <i>[Монгол, Англи эсхүл бусад хэлүүдээс тохирохыг нь бичих].</i>
1.4	Хаягууд: Мэргэжлийн байгууллага: _____ Хэнд: _____ Утас: _____ Факс: _____  Үйлчилгээ үзүүлэгч: _____ Хэнд: _____ Утас: _____ Факс: _____
1.6	Төлөөлөх эрх бүхий этгээдүүд:  Захиалагчийг төлөөлөх: _____  Үйлчилгээ үзүүлэгчийг Төлөөлөх: _____
2.1	Энэхүү гэрээ нь <i>[огноо]</i> -ээс эхлэн хүчин төгөлдөр болно.
2.2.2	Үйлчилгээг <i>[огноо]</i> өдрөөс эхлүүлнэ.
2.3	Дуусгахаар төлөвлөсөн өдөр нь <i>[огноо]</i> байна.
3.4	Даатгуулах эрсдэл ба зардлууд нь: (i) Гуравдагч талын авто машин _____ (ii) Гуравдагч талын өр төлбөр _____  iii) Захиалагчийн үүрэг хариуцлага болон ажилчдын нөхөн төлбөр _____ (iv) Мэргэжлийн үүрэг хариуцлагын даатгал _____ (v) Өмч хөрөнгө, эсхүл тоног төхөөрөмжийн эвдрэл, алдагдлын даатгал _____
3.5(г)	<i>[ Санамж: Байхгүй бол устгана уу, хэрэв байгаа бол жагсааж бичих].</i>  Бусад үйл ажиллагаа нь _____.]
3.8.1	Алдангийн хэмжээ нь өдөрт <i>[Гэрээний үнийн тодорхой хувьтай тэнцүү байхаар оруул. Ихэвчлэн алданги тооцох хувь хэмжээ нь</i>



*өдөрт гэрээний үнийн 0.05 хувиас 0.10 хувийн хооронд байдаг.]*  
байна.

Нийт гэрээнд алданги оногдуулах дээд хэмжээ нь гэрээний үнийн *[Гэрээний үнийн тодорхой хувьтай тэнцүү байхаар оруул. Ихэвчлэн алданги тооцох нийт хувь хэмжээ нь гэрээний үнийн 5 хувиас 10 хувийн хооронд байдаг]* байна.

Дутуу гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнд торгууль ногдуулах хувь хэмжээ нь *[Зөрчлийг арилгахад гарах зардал]-ын [хувь хэмжээг оруул]* байна.

Чанарын баталгаат хугацаа нь *[дуусах өдрийг тодорхойлсон огноо оруул]* хүртэл байна. .

5.1

*[Санамж: Захиалагчийн 5.1 зүйлд заасны дагуу үзүүлж болох аливаа хөнгөлөлт, тусламжийг жагсааж бичнэ үү. Хэрэв байхгүй бол “байхгүй” гэж бичнэ үү.]*

6.2(a)

Дотоодын валютаар хийгдэх төлбөрийн хэмжээ нь *[хэмжээ болон валютыг оруулна уу].*

6.2(б)

Гадаадын валют/валютауд-аар хийгдэх төлбөрийн хэмжээ нь *[хэмжээ болон валютыг оруулна уу].*

6.4

Төлбөрийг дараах хуваарийн дагуу хийнэ:

*[Санамж: (а) Доор бичигдсэн нь зөвхөн жишээ болгож хийгдсэн загвар; (б) Хэрэв дотоод болон гадаад валютуудаар хийгдэх төлбөр нь ижилхэн хуваариар хийгдэх боломжгүй бол тус тусад нь төлбөрийн хуваарь хийж болно. (в) “эхлэх огноо” гэдгийг “хүчин төгөлдөр болсон огноо,” гэж өөрчилж болно. (г) Хэрэв шаардлагатай бол ажлын гүйцэтгэл, үр дүнгийн хийсэн дэлгэрэнгүй тайлан, нотолгоо ирүүлэхийг шаардах].*

- Урьдчилгаа төлбөр: Урьдчилгаа төлбөрийн банкны баталгаа ирүүлсэн тохиолдолд үйлчилгээ эхлэх өдөр(эсхүл гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр) нийт гэрээний үнийн \_\_\_\_\_ хувийг шилжүүлнэ.
- Ажлын үр дүнгийн үзүүлэлтэд үндэслэн үйлчилгээ үзүүлэгчийн шаардлагад нийцсэн гүйцэтгэлийг захиалагч хүлээн зөвшөөрч баталгаажуулсны үндсэн дээр төлбөрийг дараах хуваарьт тогтоосон үе шатаар хийнэ:

- \_\_\_\_\_ (үе шат/хувь хэмжээг заа)
- \_\_\_\_\_ (үе шат/хувь хэмжээг заа)
- \_\_\_\_\_ (үе шат/хувь хэмжээг заа)

Хуваарийн дагуу төлбөр хийх үе шатыг заасан өдөр эсхүл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор захиалагч нь бичгээр гүйцэтгэлийг баталгаажуулсан эсхүл татгалзсан хариу өгөөгүй бол гүйцэтгэлийг баталгаажуулсанд тооцож үе шатны төлбөрийг тэр өдрөөр хийх ёстой.

Урьдчилсан төлбөрийн суутган тооцолтыг үе шатны төлбөрийн 25 хувь төлөгдсөн үеэс эхлэн 75 хувьд хүрэх үед дуусгана.

- Банкны баталгааг гэрээний нийт үнийн 50 хувь (75%) төлөгдсөний дараа буцаана.

*[Санамж: Энэхүү жишиг заалт нь тухайн гэрээ тус бүрд зориулж боловсруулагдах ёстой].*

6.5 Захиалагч 6.4 дүгээр зүйлд заасан холбогдох баримт бичгүүдийн хамт төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш [тоо] хоногийн дотор төлбөрийг хийнэ.

**[Санамж:** жишээлбэл “дөчин таван (45) өдөр,” болон, хамгийн сүүлчийн төлбөр хийх хугацааг “жаран (60) өдөр.” байхаар зааж өгч болно. ]

Хүүгийн хэмжээ [хувь] байна..

6.6 дугаар зүйлийн дагуу үнийн тохируулга [(хийгдэнэ) эсхүл {хийгдэхгүй}]

Үнийн тохируулга хийх илтгэлцүүрүүд нь:

(а) [валютын нэр]-ийн хувьд:

- (1) тохируулга хийгдэхгүй хувийн жин нь [хувь] байна. (итгэлцүүр А)
- (2) тохируулга хийгдэх хувийн жин нь [хувь] байна. (итгэлцүүр В)
- (3) тохируулга хийгдэх хувийн жин нь [хувь] байна. (итгэлцүүр С)  
Lmc болон Loc ажиллах хүчний илтгэлцүүрүүдийг {Ажиллах хүчний индексийг ашиглах эх сурвалжийг дурдах}  
Imc болон Ioc индексүүдийн [орцыг оруул] [эх сурвалжийг оруул] тооцно.

(б) [валютын нэр]-ийн хувьд:

- (1) тохируулга хийгдэхгүй хувийн жин нь [хувь] байна. (итгэлцүүр А)
- (2) тохируулга хийгдэх хувийн жин нь [хувь] байна. (итгэлцүүр В)
- (3) тохируулга хийгдэх хувийн жин нь [хувь] байна. (итгэлцүүр С)  
Lmc болон Loc ажиллах хүчний илтгэлцүүрүүдийг {Ажиллах хүчний индексийг ашиглах эх сурвалжийг дурдах}  
Imc болон Ioc индексүүдийн [орцыг оруул] [эх сурвалжийг оруул] тооцно.

**ДОЛООДУГААР БҮЛЭГ**  
**ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ МАЯГТ**

<b>БАТЛАВ</b>	<b>БАТЛАВ</b>
<b>(Мэргэжлийн байгууллагын нэр)</b>	<b>(Нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн нэр)</b>
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр]-ЫН ЕРӨНХИЙ ГЭРЭЭ**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

Огноо

Улаанбаатар хот

Нэг талаас **[Мэргэжлийн байгууллагын нэр]** (цаашид “мэргэжлийн байгууллага” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн нэр]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 20... оны ... сарын ... -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу Ерөнхий гэрээгээр **[бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх]** /аль тохирохыг сонгох/-тэй холбогдон мэргэжлийн байгууллага, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Мэргэжлийн байгууллага нь **[тендер шалгаруулалтын нэр]** гэх **[бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх]** /аль тохирохыг сонгох/ тендер шалгаруулалтыг зохион байгуулж доорх нэгж үнээр (цаашид “гэрээний нэгж үнэ” гэх) цахим дэлгүүрт байршуулахыг үүгээр хүлээн зөвшөөрөв.

№	Тээвэрлэлтийн зардал орсон нэгж үнэ /төгрөг/	Тээвэрлэлтийн зардал ороогүй нэгж үнэ /төгрөг/
1	<b>/Үнийг тоо болон үсгээр бичих/</b>	<b>/Үнийг тоо болон үсгээр бичих/</b>
2		

3. Гүйцэтгэгч нь ..... нэр төрлийн **[бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх]** /аль тохирохыг сонгох/-г Ерөнхий гэрээний хүчинтэй хугацаанд буюу 20... оны ... дугаар сарын ...-нээс 20... оны ... дугаар сарын ...-ны өдрийн хугацаанд /гурав хүртэлх жилийн хугацаа/ гүйцэтгэнэ.

4. Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтын арга болох **["шууд сонголт", "цахим үнэ хаялцуулах", "үнийн санал авах"]** /аль тохирохыг сонгох/ -ын дагуу захиалагчаас Цахим дэлгүүрт ирүүлсэн худалдан авалтын хуудаст заасан бараа, үйлчилгээг гүйцэтгэхээр шалгарсан тохиолдолд гүйцэтгэгч нь Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээг тухайн захиалагчтай байгуулна.
5. Гүйцэтгэгч нь энэ гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн бараа, үйлчилгээг гүйцэтгэж, доголдол, дутагдлыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.
6. Ерөнхий гэрээний нэгж үнэ нь өөрчлөгдөхгүй, тогтмол байна.
7. Гэрээнд холбогдох асуудлаар талууд зөвхөн албан бичгээр харилцана.
8. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
  - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;
  - Тендер ба үнийн хуваарь;
  - Гэрээний ерөнхий нөхцөл;
  - Гэрээний тусгай нөхцөл;
  - Техникийн тодорхойлолт, бараа нийлүүлэлтийн хуваарь эсхүл Ажлын даалгавар, үе шатны хуваарь;
  - Эрх хязгаарлахыг зөвшөөрсөн мэдэгдэл.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

Мэргэжлийн байгууллагыг төлөөлж:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

Гүйцэтгэгчийн төлөөлж:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Мэргэжлийн байгууллагын хаяг]

[Утас/факсын дугаар]

ТАМГА

[Гүйцэтгэгчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

## ЕРӨНХИЙ ГЭРЭЭНИЙ ДАГУУ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ

.... он.... сар.... өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Ерөнхий гэрээний гүйцэтгэгч-  
 .....**[хуулийн этгээд эсхүл иргэний нэр]** /аль  
*тохирохыг сонгох*/, түүнийг төлөөлөн ..... /албан тушаал/  
 ажилтай ..... /нэр/ (цаашид “Гүйцэтгэгч” гэх), нөгөө талаас Захиалагч-  
 ..... /хуулийн этгээдийн нэр/, түүнийг төлөөлөн  
 ..... /албан тушаал/ ажилтай ..... /нэр/  
 (цаашид “Захиалагч” гэх) дараах зүйлсийг харилцан тохиролцож  
 .....он.....сар.....өдөр байгуулав.

#### Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

- 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Иргэний хууль, Ерөнхий гэрээний журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу Ерөнхий гэрээгээр бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2. Захиалагч нь Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтын арга болох **["шууд сонголт", "цахим үнэ хаялцуулах", "үнийн санал авах"]**/аль тохирохыг сонгох/-ын дагуу Цахим дэлгүүрт ирүүлсэн худалдан авалтын хуудаст заасан бараа, үйлчилгээг гүйцэтгэх гүйцэтгэгчийн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

#### Хоёрдугаар зүйл. Гэрээний агуулга

2.1. Гэрээний зүйл:

Бараа

Үйлчилгээ

2.2. Үнийн хуваарь:

Бараа/үйлчилгээний нэр: .....	Хэмжих нэгж: .....	Багцын дугаар: .....
Тоо хэмжээ: .....	Нэгж үнэ: (тоо болон үсгээр бичих)  Тээвэрлэлтийн зардал орсон үнэ: ..... (.....) Тээвэрлэлтийн зардал ороогүй үнэ: ..... (.....)	Мөнгөний нэгж:  <b>Төгрөг</b>

Бараа хүргэх газар /  Үйлчилгээ үзүүлэх газар /  Гүйцэтгэгчийн борлуулалтын цэг

Хаяг:

Аймаг/хот:	Сум/дүүрэг:
Баг/Хороо:	Гудамж:
Шуудангийн хаяг:	Zip код:
Байршлын дэлгэрэнгүй мэдээлэл:	

Нийт гэрээний үнэ: (тоо болон үсгээр бичих)  
 .....  
 (.....)

2.3. Нийлүүлэлтийн хуваарь:

<input type="checkbox"/> Бараа	<input type="checkbox"/> Үйлчилгээ
Гэрээ байгуулагдсанаас хойш ..... хоногийн дотор бараа нийлүүлж дуусгасан байна. (Хоногийн тоог оруулах)	Гэрээ байгуулагдсанаас хойш ..... хоногийн дотор үйлчилгээ үзүүлж, дуусгасан байна. (Хоногийн тоог оруулах)
Нийлүүлэлтийн графикт хугацаа ашиглах бол доорх байдлаар нийлүүлэгдэнэ: (Тоо хэмжээнд хамаарах огноог оруулах) ..... ..... .....	Үйлчилгээ үзүүлэх графикт хугацаа ашиглах бол доорх байдлаар нийлүүлэгдэнэ: (Тоо хэмжээнд хамаарах огноог оруулах) ..... ..... .....

2.4. Бараа, үйлчилгээг дагалдах иж бүрдэл байгаа бол доорх хүснэгтийн дагуу мэдээллийг оруулах: (иж бүрдэлд барааны биет байдлын шинжийг тодорхойлж буй бараа түүнийг дагалдах үйлчилгээ, тоног төхөөрөмж эсхүл үйлчилгээ түүнийг дагалдах бараа, материал, тоног төхөөрөмж, сургалт, суурилуулалт, шалгалт, туршилт зэрэг холбогдох мэдээллийг оруулна.)

№	Зүйл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ялгагдах шинж
1.				
2.				

2.5. Энэхүү гэрээнд заасны дагуу гүйцэтгэгч нь Цахим дэлгүүрт бүртгэгдсэн техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай ижил, биет байдлын болон эрхийн доголдолгүй бараа, үйлчилгээг бэлдэж, захиалагчид хүлээлгэн өгнө.

2.6. Гүйцэтгэгч бараа, үйлчилгээнд холбогдох аливаа баримт бичгийг захиалагчид бараа, үйлчилгээг [ачуулснаар эсхүл хүлээлгэн өгөх]/аль тохирохыг сонгох/-ээр шилжүүлнэ.

### 3. Чанарын баталгаа, баталгаат засвар

3.1. Гүйцэтгэгчийн нийлүүлэх бараа, үзүүлэх үйлчилгээ нь Цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, үйлчилгээний тодорхойлолттой ижил байх бөгөөд чанарын шаардлагыг бүрэн хангасан байна.

- 3.2. Чанарын шаардлагыг техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, барааны чанарыг тодорхойлох улсын стандарт, үйлдвэрлэгчийн гэрчилгээ, загвар зэрэг холбогдох баримт бичигт үндэслэнэ.
- 3.3. Баталгаат хугацаа нь барааг нийлүүлж, үйлчилгээг үзүүлснээс хойш ..... /сарын тоог оруулах/ сарын хугацаатай байна.
- 3.4. Захиалагч баталгаат хугацаанд бараа, үйлчилгээний аливаа дутагдал доголдол, гэмтлийн талаар гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэх бөгөөд гүйцэтгэгч мэдэгдэлд заасан хугацааны дотор гэмтэл согогтой бараа, дутагдалтай үйлчилгээг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
- 3.5. Гэрээний 3.4 дэх хэсэгт заасан бараа, үйлчилгээний гэмтэл, согог, дутагдлыг арилгаснаас хойш 12 сарын дотор уг бараа, үйлчилгээнд энэ төрлийн гэмтэл согог дутагдал дахин гарсан бол уг гэмтэл согог, дутагдлыг гүйцэтгэгч үнэ төлбөргүй шуурхай арилгана.

#### **4. Үнэ төлбөр, төлбөрийн нөхцөл, нэхэмжлэл**

- 4.1. Захиалагч нь бараа, үйлчилгээг хүлээн авч, Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтад ирүүлсэн нэгж үнэд үндэслэсэн гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн дагуу төлбөрийг төлнө.
- 4.2. Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон 2.6 дахь хэсэгт заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 4.3. Гүйцэтгэгч 4.2 дахь хэсэгт заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор төлбөрийг шуурхай гүйцэтгэнэ.
- 4.4. Төлбөрийн төрөл: ..... /бэлнээр, банкны шилжүүлэг, аль алианаар/
- 4.5. Захиалагч төлбөр гүйцэтгэсэн хоногт багтаан гүйцэтгэгчид төлбөр төлсөн талаар энэ гэрээнд заасан харилцах хаягаар мэдэгдэнэ.

#### **5. Сав баглаа боодол**

- 5.1. Гүйцэтгэгч барааг аюулгүй баглаа боодолд хийж, захиалагчид барааг хүлээн авах хүртэл гэмтэл эвдрэл, устахаас сэргийлж баталгаажуулна.
- 5.2. Барааны нэгж үнэ нь тээвэрлэлтийн зардал багтсан үнэ бол баглаа боодлын үнэ нь уг үнэд багтсан байна.
- 5.3. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ захиалагчийн дараах зааварчилгааг чанд мөрдөнө:  
.....  
.....

#### **6. Барааг хүлээн авах**

- 6.1. Гүйцэтгэгч нь захиалагчид ..... /хүлээн авах газар/-т барааг хүлээлгэн өгнө.
- 6.2. Талууд хүлээн авах цэг дээр барааны тоо хэмжээ, чанарыг хуульд заасан арга ажиллагааны дагуу шалгана.
- 6.3. Захиалагч гүйцэтгэгчид.....ий дараа .....дотор /өдөр, цаг, сар/...../телеграм, факс/-аар мэдэгдэнэ.

## 7. Гэрээний хүчин төгөлдөр байдал

- 7.1. Энэхүү гэрээ талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Гэрээ нь..... оны .....сарын.....өдөр дуусгавар болно.

## 8. Тусгай нөхцөл

.....  
 .....

## 9. Бусад зүйл

- 9.1. Энэхүү гэрээ хоёр хувь үйлдэгдэх бөгөөд талуудад нэг нэг хувь хадгалагдана.  
 9.2. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээний өмнөх хэлэлцээр, харилцаа холбоо, зөвлөмж, санал хүчингүй болно.  
 9.3. Гүйцэтгэгчтэй байгуулсан Ерөнхий гэрээ, Цахим дэлгүүрт бүртгэгдсэн барааны техникийн тодорхойлолт, үйлчилгээний ажлын даалгавар, худалдан авалтын хуудас нь тус гэрээний салшгүй хэсэг болно.  
 9.4. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, цуцлахтай холбоотой аливаа маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв зөвшилцөлд үл хүрвэл Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 10. Гэрээтэй холбоотой асуудлаар харилцах талуудын мэдээлэл

Гүйцэтгэгч	Захиалагч
Худалдагчийн төлөөлөгч: ..... .	Худалдан авагчийн төлөөлөгч: ..... .
Албан тушаал: ..... .	Албан тушаал: ..... .
Утас: .....	Утас: .....
Хаяг: ..... . ..... . ..... . ..... .	Хаяг: ..... . ..... . ..... . ..... .
Худалдагчийн банкны мэдээлэл: ..... .	Худалдагч авагчийн банкны мэдээлэл: .....



## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Гүйцэтгэгчийн төлөөлж:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]\_\_\_\_\_

Захиалагчийг төлөөлж:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Гүйцэтгэгчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2023 оны 11 дүгээр сарын 03

Тендер шалгаруулалтын нэр: **“Төрийн байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай оффисын техник хэрэгслийг ерөнхий гэрээгээр худалдан авах”**

Тендер шалгаруулалтын дугаар: ТХААГ/202311161

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос: **“Төрийн байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай оффисын техник хэрэгслийг ерөнхий гэрээгээр худалдан авах”** тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: **Үгүй**

Тендерийг **2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 14 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 14 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг,  
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР,  
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо,  
Энхтайваны өргөн чөлөө-16А, Засгийн газрын IX байр,  
Утас: 51-260056  
Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**